



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА

**ЦУВРАЛ 16**

Улаанбаатар, 2024

ННА 67  
ДАА 340  
Ш-978



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ЦУВРАЛ 16

### СУДЛААЧИД:

М.Нармандах  
Ц.Дэлгэрмөрөн  
У.Энхсар  
Б.Тэмүүлэн  
Б.Одонгэрэл

Дугаар хариуцсан редактор: Г.Оюунболд

© Нээлттэй Нийгэм Форум, 2024.

Энэхүү цувралд багтсан судалгаануудын дүгнэлт, санал нь судалгааг хийж гүйцэтгэсэн судлаачдын байр суурь, үзэл бодол бөгөөд Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN 978-9919-9136-4-9

# Шүүхийн шийдвэрийн судалгаа ЦУВРАЛ 16

## 1 МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

7

## 2 ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЭСРЭГ ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

57

## ӨМНӨХ ҮГ

“Шүүхийн шийдвэр судалгаа” цувралын 16 дах дугаар нь эрүүгийн хэрэг маргаан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн судалгааг багтаасан дөрөвдэх буюу сүүлийн дугаар болж байна. Нээлттэй Нийгэм Форумын тэтгэлгээр нийт 10 эрүүгийн шүүхийн шийдвэрийн судалгааг хийж гүйцэтгэснийг энэхүү цувралаар дамжуулан уншигч Та бүхэнд хүргэлээ.

Энэ удаагийн дугаарт Б.Нармандах ахлагчтай багийн хийж гүйцэтгэсэн “Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн судалгаа” болон судлаач Одонгэрэлийн гүйцэтгэсэн “Байгаль орчны эсрэг гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн судалгаа” багтсан байна. Эдгээр гэмт хэрэг нь бусад гэмт хэргийн гаралттай харьцуулахад төдийлөн түгээмэл биш хэдий ч шийдвэрлэхэд нарийн төвөгтэй байдлаараа мөрдөн шалгах, яллах, шүүн таслах аль аль шатанд сорилт дагуулдаг хэргүүд юм. Тухайлбал, мөнгө угаах гэмт хэргийн хувьд хууль хэрэглээний практик нэг мөр болоогүй байгаа нь тус гэмт хэргийг хэт ерөнхий байдлаар томъёолж хуульчилсантай холбоотой гэж судлаачид үзжээ. Харин байгаль орчны эсрэг гэмт хэргийн хувьд хуулийн этгээдэд ял оногдуулахтай холбоотой асуудал нэг мөр болоогүй нь асуудал дагуулж байгааг судлаач онцолсон байна. Энэ мэтчилэн шүүхийн практик, шийдвэрээс эрх зүйн орчны хувьд болон хууль хэрэглээний хувьд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх санал дэвшүүлэх нь шүүхийн шийдвэр судалгааны үндсэн зорилго билээ.

Шүүхийн шийдвэрийн судалгааг гүйцэтгэсэн нийт судлаачид, редактор Г.Оюунболд нартаа талархал илэрхийлж, цаашдын судалгаа шинжилгээний ажилд нь амжилт хүсье. Уншигч та бүхэн бидний ажлыг сайжруулах санал зөвлөмжөө манай байгууллагын [www.forum.mn](http://www.forum.mn) цахим хуудас болон нийгмийн сүлжээний хаягт хандан ирүүлэх боломжтой.

*П.Эрдэнэжаргал  
Гүйцэтгэх захирал*

## РЕДАКТОРЫН ҮГ

Энэ удаагийн дугаарт орж буй шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ нь мөнгө угаах болон хүрээлэн байгаа орчны эсрэг зарим гэмт хэргийг хамарсан бөгөөд судлаачдаас чамгүй хүчин чармайлт шаардсан судалгаа болсныг тэмдэглэх нь зүйтэй. Эдгээр төрлийн гэмт хэргийн онцлог, үйлдлийн шинжүүд байнга хувьсан өөрчлөгдөхийн хэрээр гэмт хэргийг зүйлчлэх, шүүхээр эцэслэн шийдвэрлэхэд тулгамдаж буй асуудлыг цаг алдалгүй илрүүлэх нь хууль хэрэглээний хувьд нэн ач холбогдолтой юм.

Цаашид мөнгө угаах болон хүрээлэн байгаа орчны эсрэг шинэ төрлийн гэмт хэргүүдийн тоо, нийт гэмт хэрэгт эзлэх жин байнга нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд энэхүү шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээнүүд нь өмгөөлөл, прокурорын хяналт, шүүн таслах ажиллагаанд төдийгүй хууль зүйн сургуулийн сургалтад хэрэглэгдэхүүн болох боломжтой болсон гэж редакторын хувьд үзэж байна.

Өнгөрсөн хугацаанд шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээний арга зүйг сайжруулах, судлаачдыг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх замаар эрх зүйн шинэтгэлд хувь нэмэр оруулж ирсэн Нээлттэй нийгэм форумын хамт олонд талархал илэрхийлье.

Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хэрэглээ, үр нөлөөг нэмэгдүүлэхэд шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ, тэдгээрт хамаарах тайлан судалгааны ажлууд түлхэц болж байгаа гэдэгт эргэлзэхгүй байна.

*Г.Оюунболд  
Редакцын зөвлөлийн гишүүн*

# 1

## МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



#### **МАГСАРЫН НАРМАНДАХ (LLM)**

Монгол өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийг бакалавр, магистр зэрэгтэй төгссөн. Мөнгө угаах гэмт хэргийн чиглэлээр докторантын судалгааны ажил хийж байгаа.



#### **ЦЭРЭННАДМИДЫН ДЭЛГЭРМӨРӨН (LLM)**

Монголын өмгөөлөгчдийн холбоо, Хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийг бакалавр зэрэгтэй төгссөн.

Судалгааны  
багийн ахлагч:  
М.Нармандах

Судлаачид:  
Ц.Дэлгэрмөрөн  
У.Энхсар  
Б.Тэмүүлэн

Тус судалгааны багт МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Ууганбаатарын Энхсар, Батхүүгийн Тэмүүлэн нар туслах судлаачаар ажиллалаа.

## ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .....	9
УДИРТГАЛ .....	10
НЭГ. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ШИНЖ.....	12
ХОЁР. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....	19
ГУРАВ. ШҮҮХИЙН ПРАКТИК, ДҮН ШИНЖИЛГЭЭ.....	24
ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ .....	45
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ .....	51

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АТГ	Авлигатай Тэмцэх Газар
МУТАНДБ	Мөнгө угаахтай тэмцэх Ази, Номхон далайн бүлэг
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
СМА	Санхүүгийн мэдээллийн алба
УИХ	Улсын Их Хурал
УЕП	Улсын ерөнхий прокурор
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий Газар
ЭХ	Эрүүгийн хууль
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

## УДИРТГАЛ

Үндэстэн дамнасан хүний наймаа, мансууруулах бодисын худалдаа, авлига, санхүүгийн залилан, цахим гэмт хэрэг улам бүр нэмэгдэж улмаар гэмт хэргийн замаар бий болсон хууль бус орлого, мөнгө, эд хөрөнгөө хууль, хяналтын байгууллага илрүүлэхээс өмнө гадаад улс орнуудад хөрөнгө оруулж хууль ёсны орлого болгон хувиргаж байна. Ингэхдээ гэмт хэрэгтнүүд санхүүгийн системийн хяналт сул, эрх зүйн зохицуулалт байхгүй улс орнуудыг сонгож гэмт хэрэг үйлдэх болсон тул улс орнууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд гол анхаарлаа хандуулах болжээ.

Улс орнууд дотоодын эдийн засаг, түүний дотор банк, санхүү бизнесийн орчныг эрүүл, аюулгүй байлгах, гадаад худалдаа, мөнгөн гүйлгээ, валютын урсгалын хяналтыг чангатгах, бохир мөнгө, хууль бус бизнесийн үйл ажиллагааг таслан зогсоох, үндэсний хууль тогтоомж, эрх зүйн орчныг сайжруулах зорилгоор олон улсын банк, санхүү, хууль хяналтын байгууллагатай хамтран ажилладаг.

Монгол Улс Ази, Номхон далайн бүсийн мөнгө угаахтай тэмцэх байгууллагад гишүүнээр элссэнтэй холбогдуулан 2006 онд ФАТФ-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд үнэлгээ хийж, “өндөр эрсдэлтэй болон хамтран ажилладаггүй улс” гэсэн ангилал буюу “хар саарал жагсаалт”-д оруулсан. ФАТФ-аас өгсөн зөвлөмжийн дагуу Монгол Улс 2013 онд “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн шинэчилсэн найруулга, 2014 онд “Эрүүгийн хууль”-ийн нэмэлт өөрчлөлтийг тус тус баталж, Эрүүгийн хуульд анх удаа

“Мөнгө угаах” гэмт үйлдлийг гэмт хэрэгт тооцсоноор 2014 оны 6 дугаар сард “хар сааралт жагсаалт”-аас гарсан байна.

Мөнгө угаах гэмт хэрэг хэд хэдэн улсыг дамнан нууц хэлбэрээр үйлдэгдэж түүнийг илрүүлэхэд цаг хугацаа, ажиллагаа их шаардагддаг бол цахим гэмт хэргийг хэн, хаана, ямар улсад үйлдсэн болохыг олж илрүүлэх, тогтоох боломжгүй байдаг. Тиймээс хохирогчийн хохирлыг барагдуулах боломжгүй нөхцөл байдал үүсч байна. Цаашид энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх, хуульчдыг чадавхжуулах, гэмт хэргийн талаар судалгаа шинжилгээ тогтмол хийх, улс орнуудын сайн туршлагаас суралцах эрх зүйн орчныг улам боловсронгуй болгох шаардлагатай.

Тиймээс мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэж буй шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг судлах, шалтгааныг тогтоох, эрх зүйн орчныг сайжруулах талаар санал дэвшүүлэхэд энэхүү судалгааны зорилго оршино.

## НЭГ. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ОЙЛГОЛТ, ШИНЖ

Анх 1928 онд АНУ-д “L'expresse” сонины сэтгүүлчид “*Хувцас биш мөнгө угааж байна*” гэсэн нийтлэлийг олон нийтэд мэдээлснээр мөнгө угаах (money laundering) гэсэн нэр томъёо гарсан байна.<sup>1</sup> АНУ-ын Засгийн газраас энэхүү хууль бус үйлдэл, үйл ажиллагааг таслан зогсоохын тулд 1986 онд анх удаа “Мөнгө угаахтай тэмцэх тухай” бие даасан хуулийг баталж, мөнгө угаах үйлдлийг эрүүгийн гэмт хэрэгт тооцжээ.<sup>2</sup>

“**Мөнгө**” (англ. *money*; ор. *деньги*) гэсэн ойлголтын хэл зүйн утгыг “Монгол хэлний тайлбар толь” бичгүүдэд<sup>3</sup> аливаа юмсыг худалдан авах ба худалдах өртгийн хэмжүүр гэсэн бол “*Эрх зүйн толь бичиг*”-т 1.“...төлбөртэй шинжийг агуулдаг эд хөрөнгийн харилцааны аливаа бараг бүх объектыг орлож чадахуйц төлбөрийн, өртгийн, өртөг хадгалах хэрэгсэл...” эд юмсыг орлож чадах үнэт цаас”, 2.“...бүх бүтээгдэхүүн, үйлчилгээ, арилжаа, солилцооны өртгийг илэрхийлэгч нийтлэг чанартай бараа...”<sup>4</sup> гэж тайлбарладаг.

Харин эрх зүйн талаас нь эрх зүйн толь бичигт “**Мөнгө угаалт**” (англи. *money laundering*; ор. *отмывение денежных средств*) 1. Гэмт хэргийн улмаас олж авсан мөнгө буюу бусад эд хөрөнгийг хууль ёсны болгох зорилгоор хөрвүүлэх үйл ажиллагаа, 2. Хууль

бусар олсон эд хөрөнгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулах<sup>5</sup> гэж тайлбарласан байна. Хууль бус ажиллагаанаас олсон орлогыг тээвэрлэх, шилжүүлэх, хөрвүүлэх, хувиргах буюу хууль ёсны дагуу олж авсан бусад мөнгө, хөрөнгөтэй нийлүүлэх замаар эдгээр орлогын мөн чанар, эх үүсвэр, зарцуулалт, шилжилт хөдөлгөөн, өмчлөлийн талаарх мэдээллийг нуун далдлах, төөрөгдүүлэх үйл ажиллагаа гэж тодорхойлжээ.

Эрх зүйн хувьд “**Мөнгө угаах** (money laundering)” гэмт хэргийг гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөө чөлөөтэй ашиглах, захиран зарцуулах боломжийг бүрдүүлж, тухайн мөнгөн хөрөнгийг хуулийн дагуу олсон орлого мэтээр цэвэрлэж буй үйл ажиллагаа<sup>6</sup> гэж тодорхойлсон байдаг. Хууль бус үйл ажиллагаанаас олсон орлогынхоо эх үүсвэрийг нуун дарагдуулж, хэлбэр дүрсийг нь хувиргаж, улмаар эдийн засгийн эргэлтэд оруулж “бохир” мөнгийг “цэвэр” буюу хууль ёсны орлого мэт харагдуулах оролдлого нь мөнгө угаах гэмт хэрэг болдог.<sup>7</sup> Энэ гэмт хэрэг нь тухайн хөрөнгө, орлогыг эрсдэлд өртүүлэлгүйгээр хэрэглэж, ашиглах боломжийг олгодгоороо онцлог юм. Хууль бус үйл ажиллагаа нь их хэмжээний хөрөнгө, орлогыг бий болгодог бөгөөд гэмт этгээд, гэмт бүлэглэлүүд ашиг олох гэсэн хувийн сонирхол, зорилго тодорхойлсон байдаг.

Гэмт хэрэгтнүүд хууль бус ажиллагаанаас олсон хөрөнгө, орлогоо захиран зарцуулах боломжтой болгохын тулд санхүүгийн системд нэвтрүүлж, жинхэнэ эх үүсвэрийг нь нуун дарагдуулж, төөрөгдүүлэх замаар хууль ёсны орлого мэт харагдуулахаар ажилладаг. Үүний тулд орлогын эх үүсвэрийн зүсийг нь хувиргах, хэлбэрийг өөрчлөх, эсхүл бусдын анхааралд бага өртөх газарт хөрөнгө, мөнгийг байршуулах арга хэмжээг авдаг. Онолын хувьд

<sup>1</sup> Дам ишлэв.,ХЗҮХ, Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, түүнтэй тэмцэх асуудал УБ., 2013 он.

<sup>2</sup> History of Anti-Money Laundering Laws, Money Laundering Control act (1986), <https://www.fincen.gov/history-anti-money-laundering-laws>

<sup>3</sup> Монгол хэлний их тайлбар толь болон Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он.

<sup>4</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. УБ., 2011. 286 дах тал.

<sup>5</sup> С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. УБ., 2011. 287 дах тал.

<sup>6</sup> Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар, “Эдийн засгийн гэмт хэрэг II”, УБ., 2018. 194 дах тал.

<sup>7</sup> Монгол банк, Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь, УБ., 2020 он, 6 дах тал.



мөнгө угаах гэмт хэргийг хууль бус орлогыг байршуулах, тараах буюу гүйлгээнд оруулах, буцааж төвлөрүүлэх гэсэн 3 үе шатанд хувааж үздэг ажээ.

**1. Байршуулах үе шат (Placement):** Гэмт этгээд, гэмт бүлэглэлүүдийн хувьд гэмт хэрэг үйлдэж олсон их хэмжээний бэлэн мөнгийг анхны эх үүсвэрээс холдуулж, банкны ажилтны анхаарал татахгүй хэмжээгээр хэсэгчлэн хувааж санхүүгийн системд нэвтрүүлэх, хэд хэдэн төрлийн банканд хүмүүсийн нэр дээр данс нээх, үнэт цаас, чек, хувьцаа авах, бага хэмжээгээр гадаад валютыг хөрвүүлж авах, үнэтэй үл хөдлөх хөрөнгө, машин, ховор түүхийн олдвор, уран зураг, үнэт чулуу худалдан авах эсхүл санхүүгийн хяналт шалгалт харьцангуй сул улс оронд тухайн бохир мөнгийг гаргаж банканд байршуулдаг.<sup>8</sup> Суурь гэмт хэргийг үйлдсэн гэмт этгээд хууль бус мөнгөн хөрөнгийг халхавч компани, гуравдагч этгээдээр дамжуулан байршуулдаг.

**2. Хувиргах буюу нуун далдлах үе шат (Layering):** Байршуулах үе шат амжилттай хэрэгжсэний дараа гэмт хэргийн замаар олсон хөрөнгийг олон төрлийн гүйлгээнд оруулах, үнэт цаас, чек зэрэг мөнгөн хэрэгсэл болгох, олон тооны данс ашиглан нэгээс нөгөөд нь шилжүүлж санхүүгийн системд эргэлдүүлэх, зорилгогүйгээр үнэтэй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө худалдан авах, буцааж худалдан борлуулах замаар улс дамжуулан гүйлгээ хийдэг байна. Энэ шатанд “угаасан” мөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого мэт харагдуулахыг зорьдог тул мөнгө угаах үйлдлийг олж тогтооход хүндрэлтэй болгодог.

**3. Буцаан төвлөрүүлэх буюу нийлүүлэх үе шат (Integration):** Энэ үе шатанд нэмэлт гүйлгээ хийж хөрөнгийг хууль ёсны мэт харагдуулахыг зорих бөгөөд гэмт хэргийн гаралтай хөрөнгийг олж тогтооход мэдээлэгчийн туслалцааг авдгаараа халхавчлах үе шатнаас ялгаатай байдаг. Онолын хувьд гарал үүслийг нь тогтооход

<sup>8</sup> Досжин Б, Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг харьцуулан судлах нь УБ., 2018 он, 4-5 дах тал.

бэрх болсон эсхүл хууль ёсны болгосон мөнгөн хөрөнгийг эргүүлэн өөрийн нэр дээр төвлөрүүлдэг гэж үздэг байна. Энэ шатанд мөнгө угаасан үйлдлийг тогтоох нь өмнөх хоёр шаттай харьцуулахад боломжгүй юм.<sup>9</sup> Дээр дурдсан үе шатууд бүрэн хэрэгжсэн тохиолдолд “мөнгө угаалт” явагдсан гэж ойлгож болохгүй ба зарим тохиолдолд дээрх үе шатын хоёр эсхүл гурав нь нэг үйлдлээр хийгдэж болдог.

Эндээс үзэхэд мөнгө угаах гэмт хэрэг нь суурь гэмт хэрэг үйлдэгдэх үе шатаас эхэлдэг бөгөөд мөнгө угаах<sup>10</sup> нь их хэмжээний мөнгийг хууль бусаар зах зээлд нийлүүлж, гэмт хэргийн замаар олсон орлогоо өөрсдийн бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, бэхжүүлэх, зохион байгуулалтай гэмт хэргийн бүлэглэлийг санхүүжүүлэхэд зарцуулдаг байна.

Тиймээс ФАТФ-ын зөвлөмжид “мөнгө угаах гэмт хэрэгт бүх хүнд гэмт хэргийг түүний дотор өргөн хүрээний суурь гэмт хэргийг хамруулбал зохих” талаар тусгасан байна. Түүнчлэн Палермогийн конвенцод оролцогч бүх улс орнууд уг конвенцын мөнгө угаах гэмт хэргийг “хамгийн өргөн хүрээний үндсэн гэмт хэрэгт” тооцохыг шаарддаг байна.<sup>11</sup> ФАТФ-ын 40 зөвлөмжийн 1, 2 дугаар хэсгийн

<sup>9</sup> Мөн тэнд.,

<sup>10</sup> Гэмт хэрэгтнүүд их хэмжээний бэлэн мөнгийг дараах хууль бус үйл ажиллагаанаас олдог бөгөөд мөнгө угаах гэмт хэргийн үндэс болдог. Үүнд:

- 1 Хууль бус галт зэвсгийн наймаа;
- 2 Хүний, эд эрхтний наймаа;
- 3 Хар тамхины худалдаа;
- 4 Эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх;
- 5 Мөнгөн тэмдэгт хуурамчаар үйлдэх;
- 6 Авлига, хээл хахууль;
- 7 Татвараас зайлсхийх;
- 8 Байгаль орчны эсрэг, гэмт хэрэг;
- 9 Хулгай, дээрэм;

<sup>10</sup> Цахим гэмт хэргийн хохирогчоос шаардаж авсан барьцаа төлбөр, далд вэб дэх хууль бус үйл ажиллагааны төлбөр болгож биткойн,этериум зэрэг криптовалютаар олсон орлого.

<sup>11</sup> Палермогийн конвенц, 2 (2) дугаар зүйл, <http://www.undcp.org/adhoc/palermo/conv-main.html>



Мөнгө угаах болон хөрөнгө хураах бүлэгт: “Улс орнууд мөнгө угаах гэмт хэргийг Венийн болон Палермогийн конвенцын үндсэн дээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёстой” гэж мөнгө угаах гэмт хэргийн техникийн болон хууль эрх зүйн тодорхойлолтыг тусгайлан тусгаж, мөнгө угаах гэмт хэргийн үндсэн гэмт хэрэгт тооцох ёстой гэмт хэргүүдийн жагсаалтыг баталсан<sup>12</sup> байна.

Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Суурь гэмт хэрэгт бүх гэмт үйлдлийг хамааруулах;
2. Хүнд гэмт хэргийн ангилалд хамаарах үйлдлийг тодорхойлох;
3. Ноцтой гэмт хэргийн ангилалд хамаарах босго; эсхүл үндсэн (суурь) гэмт хэрэгт оногдуулах хорих ялаас (босго аргачлал)<sup>13</sup> хамаарах;
4. Үндсэн (суурь) гэмт хэргийн жагсаалт гаргах;
5. Эдгээр аргуудын хослуулан холимог аргачлалаар хэрэглэх.<sup>14</sup>

Энэхүү тодорхойлолтоос дүгнэхэд “мөнгө угаах” гэмт хэргийн өмнө суурь гэмт хэрэг үйлдэгдсэн байна. Өөрөөр хэлбэл мөнгө угаах гэмт хэргийн үе шатуудын өмнө хууль бусаар мөнгө, эд хөрөнгө, орлого олсон байх бөгөөд хууль бусаар орлого олж буй үйлдэл нь гэмт хэрэгт тооцогдох явдал юм. Үүнийг мөнгө угаах гэмт хэргийн **“суурь гэмт хэрэг”** гэж үзэж байна.

Суурь гэмт хэргийг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгтэй холбогдох эрсдэлтэй гэмт хэрэгт

<sup>12</sup> ФАТФ 40 зөвлөмж, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын стандарт, Зөвлөмж 1, <https://fiu.mongolbank.mn/file/files/documents/cma/20180531F2.pdf>

<sup>13</sup> Үндэсний хууль тогтоомжийн дагуу хүнд гэмт хэргийн ангилалд багтдаг бүх гэмт хэргийг хамруулах, эсвэл нэг жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгэдэг гэмт хэргийг хамруулах, гэмт хэргийн хамгийн бага ялыг тогтоодог хууль эрх зүйн тогтолцоо бүхий улс орнуудыг хувьд суурь гэмт хэрэг нь зургаан сараас дээш хугацаагаар хорих ялаар шийтгэдэг бүх гэмт хэргийг хамааруулна.

<sup>14</sup> Global corruption: Law, theory & practice, Chapter 4 Money laundering, April 2018, 354 дэх тал.

тооцдог. Өөрөөр хэлбэл суурь гэмт хэргийн улмаас олсон бохир мөнгө гэдгийг мэдсээр байж байршуулж, нуун далдалж, хууль ёсны дагуу олсон мөнгө болгож хувиргаж, эргэлтэд оруулах үйлдлийг хамааруулах юм.<sup>15</sup> Мөнгө угаах гэмт хэрэг үйлдэгч нь анхнаасаа хууль бусаар олсон орлогоо угаах зорилгоор суурь гэмт хэрэг үйлдэгддэг.

Мөнгө угаах гэмт хэргийн шинжид дараах үйлдлийг хамааруулна. Үүнд:

- Суурь гэмт хэрэг үйлдсэний үр дүнд эсхүл үйлдэхэд аливаа хэлбэрээр оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж уг хөрөнгө, орлогын эх үүсвэрийг халхавчлах, нуун далдлах;
- Суурь гэмт хэрэг үйлдсэний үр дүнд эсхүл үйлдэхэд аливаа хэлбэрээр оролцсоны үр дүнд бий болсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүний жинхэнэ мөн чанар, эх үүсвэр, байрлал, захиран зарцуулах арга, хөдөлгөөн, хөрөнгөтэй холбоотой жинхэнэ эрх, эсхүл эзэмшигчийг халхавчлах, нуун дарагдуулах;
- Гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд гэмт үйлдлийнхээ эрх зүйн үр дагавраас зайлсхийхэд нь туслах зорилгоор хууль бус хөрөнгө, орлогыг хувиргах, шилжүүлэх;
- Гэмт хэрэг үйлдсэн, эсхүл түүнд оролцсон үйлдлийн үр дүнд бий болсон хөрөнгө, орлогыг хүлээн авахдаа энэ тухай мэдсээр байж авсан, эзэмшсэн, ашигласан.

Хууль бус хөрөнгө, орлогыг угаах аливаа арга, төрөл, хэлбэрийг мөнгө угаах гэмт хэрэгт тооцох талаар тусгасан байна. Үүнд:

1. Өөрөө угаах (Self laundering),
2. Гуравдагч этгээд угаах (Third party laundering),
3. Дангаар угаах (Stand laundering),

<sup>15</sup> Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар. “Эдийн засгийн гэмт хэрэг II”, 2018 он .195 дах тал

Дээрх гэмт хэргийн төрлийг Палермогийн конвенцод “дотоодын хууль тогтоомжийн суурь зарчимтай зөрчилдөх тохиолдолд суурь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг конвенцын 6.1-д заасанд хамааруулахгүй байх боломжтой” гэж заасан нь ФАТФ-ын Зөвлөмж 3-т өөрөө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцохыг шаардсан стандарттай нийцдэггүй байна.

Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг Их Британийн хуульд хоёр үндсэн хэлбэрээр тодорхойлсон. Гэмт хэрэг үйлдэж олсон орлогоо өөрөө угаах, Бусдын үйлдсэн гэмт хэргээс олсон орлогыг угаах гэсэн шинжийг тогтоосон байна. Нидерландын Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн хүн өөрөө Self laundering буюу гэмт хэргийн гарал үүслийг нуун дарагдуулах, далдлах зорилготой үйлдэл хийсэн бол хорих, торгох ялаар шийтгэхээр хуульчилсан.

## ХОЁР. МӨНГӨ УГААХ ГЭМТ ХЭРГИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Монгол Улсын хувьд “Мөнгө угаах” гэмт хэргийг анх 2002 оны Эрүүгийн хуулиар зохицуулсан бөгөөд эрх зүйн зохицуулалтыг түүхчлэн авч үзвэл:

Хүснэгт 1. Эрх зүйн зохицуулалтын түүхэн товчоон

<p>1993.02.15-240 дүгээр зүйл</p> <p><b>Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах</b></p>	<ol style="list-style-type: none"> <li>1. <u>Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан</u> бол нэг жил хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хорин мянгаас жаран мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.</li> <li>2. Энэ хэргийн их хэмжээтэй буюу байнга хийсэн бол гурван жил хүртэл хугацаагаа хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.</li> <li>3. <u>Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр борлуулахаар олж авсан буюу хадгалсан, эсхүл борлуулсан</u> бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгэнэ.</li> <li>4. Энэ зүйлийн гурав дах хэсэгт заасан хэргийг их хэмжээтэй байнга хийсэн бол долоон жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</li> </ol>
<p>2002.01.13-163 дугаар зүйл</p> <p><b>Хууль бусаар олж авсан хөрөнгө, мөнгийг ашиглах</b></p>	<p>163.1. <u>Илт хууль бусаар олж авсан мөнгө, хөрөнгө гэдгийг мэдсээр байж санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагаанд оролцуулсан үйлдэл</u></p>

<p>2002.01.03-155 дугаар зүйл</p> <p><b>Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах</b></p>	<p>155.1. Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж урьдчилан амлалгүйгээр авсан, хадгалсан, борлуулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.</p>
<p>2008.02.01-268<sup>1</sup> дугаар зүйл</p> <p><b>Мөнгө угаах</b></p>	<p>268<sup>1</sup>.1. <u>Зэвсэг, хар тамхи, хүч худалдаалах, эсхүл хуурамч мөнгөн тэмдэгт үйлдвэрлэж олсон орлого, түүнчлэн зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, терроризмыг санхүүжүүлэх зорилготой илт хууль бус эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж эх үүсвэрийг нь халхавчлах буюу нуун далдлах, эсхүл уг эд хөрөнгийг хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулсан</u> бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>268<sup>1</sup>.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>268<sup>1</sup>.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>
<p>2009.12.24-1661 дугаар зүйл</p> <p><b>Мөнгө угаах</b></p>	<p>1661.1. <u>Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэтгэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, хувиргасан бол</u> хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p>

	<p>1661.2. Энэ хэргийг давтан буюу бүлэглэж, эсхүл албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн, түүнчлэн их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>1661.3. Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн, эсхүл онц их хэмжээний орлого олсон бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”</p>
<p>2014.01.16-166<sup>1</sup> дүгээр зүйл<sup>16</sup></p> <p><b>Мөнгө угаах</b></p>	<p>166<sup>1</sup>.1. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуух, далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавиас нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>166<sup>1</sup>.2. Энэ гэмт хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан, эсхүл албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн, эсхүл зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>166<sup>1</sup>.3. Энэ гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гурван зуугаас таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.</p>

<sup>16</sup> Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдсэн аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эсхүл эд хөрөнгийн эрхийг нуусан, далдалсан бол.


<p>2015 оны ЭХ-ийн 18.6 дугаар зүйл</p> <p><b>Мөнгө угаах</b></p>	<ol style="list-style-type: none"><li>1. <u>Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хүүлийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан</u> бол зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</li><li>2. Энэ гэмт хэргийг:<ol style="list-style-type: none"><li>2.1. энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг таван жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;</li><li>2.2. байнга тогтвортой үйлдэж;</li><li>2.3. албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</li></ol></li><li>3. Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</li><li>4. Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.</li></ol>
---	---

2002 оны Эрүүгийн хуулийн “Мөнгө угаах” гэмт хэргийн зохицуулалтад гурван өөр объектив шинжийг зааж, тэдгээрийн аль нэг хангагдахад Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэнд тооцож байсан. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар 2002 оны ЭХ-ийн 1661 дүгээр зүйлд заасан “эсхүл” гэдэг үгний оронд “цэгтэй таслал” тавьж хэлбэрийн хувьд өөрчлөлт орсон байна. Өөрөөр хэлбэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар мөнгө угаах гэмт хэрэг агуулгын хувьд өөрчлөгдөөгүй байна.




## ГУРАВ. ШҮҮХИЙН ПРАКТИК, ДҮН ШИНЖИЛГЭЭ

График 1. Мөнгө угаах гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдал, 2013-2023 он



Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлд “Гэмт хэргийн улмаас олсон орлого” гэж хамрах хүрээг өргөжүүлэн томъёолсноор 2016 оноос хойш “Мөнгө угаах” гэмт хэрэг шийдвэрлэлт эрс өсч, шийтгэх тогтоолын 95 хувийг “гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэдсээр байж түүнийг хувьдаа авах, эзэмших болон зарцуулах” гэмт хэргүүд эзэлж байна. Харин ЭХ-ийн 18.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэрэг шүүхээр огт шийдвэрлэгдээгүй байна.

График 2. 2020, 2021, 2022 оны эхний 6 сард Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйл (мөнгө угаах)-ээр шалгасан хэргийн харьцуулсан статистик



Цагдаагийн байгууллагад 2021 онд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйл (Мөнгө угаах) ангиар мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, давхар зүйлчлэлтэй хэргүүдийг задалж, 2022 онтой харьцуулж харуулбал:<sup>17</sup>

Хүснэгт 2. Суурь гэмт хэргийн төрөл

Зүйл заалт	2021	2022
Мөнгө угаах /дан/ 18.6	26	38
Хулгайлах /17.1/	37	64
Дээрэмдэх /17.2/	6	16
Залилах /17.3/	80	75
Хөрөнгө завших /17.4/	25	23
Мал хулгайлах /17.12/	21	20
Татвар төлөхөөс зайлсхийх /18.3/	86	38
Банк хууль бусаар байгуулах, банкны төлбөрийн чадвар алдагдуулах /18.13/	2	1
Хууль бусаар ашигт малтмал хайх /24.2/	7	5
Цахим мэдээлэлд хууль бусаар халдах /26.1/	5	5

2002 оны ЭХ-ийн 155 дугаар зүйлд заасан “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг авах, борлуулах” гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг 2015 оны ЭХ-ийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийн шинжид хамааруулснаас уг гэмт хэргийн гаралт өссөн дүнтэй харагдаж байна.

Эрүүгийн хуульд заасан бүх гэмт хэргийг үйлдэж, тэдгээр гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгийг эзэмшсэн, ашигласан, захиран зарцуулсан бол Мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэнд тооцохоор байна. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг анх ЭХ-ийн 2008 онд нарийвчлан зохицуулсан хэдий ч суурь

<sup>17</sup> Тайлбар: Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд заасан “Мөнгө угаах” гэмт хэргийн тоон мэдээг Цагдаагийн байгууллагын нэгдсэн систем болон Монгол Улсын Ерөнхий прокурорын газрын гэмт хэргийн нэгдсэн сангаас боловсруулсан болно (ЭЦА-аас зөвшөөрөл авсан).

гэмт хэргүүдийг тодорхой төрлийн гэмт хэргүүдээр хязгаарлаж, хязгаарлагдмал хүрээнд авч үзсэн нь зарим төрлийн гэмт хэргийг орхигдуулан нөгөө талаар эрх зүйн хийдэл үүсгэж байсан.

Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэхдээ практикт суурь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг Мөнгө угаах гэмт хэрэгт ихэнхи тохиолдолд гэм буруутайд давхар тооцож шийдвэрлэж байна. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг зүйл ангиар нь задалж үзвэл:

Хүснэгт 3. Суурь гэмт хэргийн гаралт

ЭХ-ийн зүйл анги	2020	2021	2022	2023 (4 сар)	Нийт
11.6 Хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах	3	-	2	1	6
13.5 Заналхийлэх	-	-	-	1	1
17.1 Хулгайлах	18	19	18	7	62
17.2 Дээрэмдэх	16	2	6	1	25
17.3 Залилах	2	2	3	4	11
17.4 Хөрөнгө завших	4	2	3	-	9
17.5 Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, алдуул мал завших	9	4	4	2	19
17.12 Мал хулгайлах	14	6	12	3	35
20.3 Зохион байгуулалттай гэмт бүлэглэх байгуулах, түүнд элсэх	-	1	1	-	2
20.7 Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар ашиглах	1	-	-	-	1

Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дийлэнх суурь гэмт хэрэг нь хохирол багатай ахуйн хүрээнд үйлдэгддэг хулгайлах, дээрэмдэх, залилах, мал хулгайлах, эд хөрөнгө завших гэмт хэргүүд эзэлсэн байна.

Гэтэл хулгайлах, дээрэмдэх, завших, эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэргүүд нь мөнгө угаах гэмт хэргүүдийн үе шатуудыг хангахгүй, шууд үйлдэгддэг тул мөнгө угаах гэмт






хэргийг ахуйн хүрээний нэг үйлдэлтэй гэмт хэргээс ялгах шаардлагатай гэж судлаачийн хувьд үзэж байна. Учир нь мөнгө угаах гэмт хэрэг дангаараа улс орны санхүүгийн системийг алдагдуулах зэрэг нийгэм, эдийн засагт хор хохирол өндөртэй гэмт хэрэг юм. Тиймээс олон улсын санхүүгийн байгууллагаас эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хахууль авах, үндэслэлгүйгээр хөрөнгөжих, татвар төлөхөөс зайлсхийх, кибер орчинд хууль бусаар халдах зэрэг гэмт хэргүүдээс мөнгө угаагдах өндөр эрсдэлтэй болохыг дүгнэж, улс орнуудын эрсдлийн үнэлгээ тогтоохдоо шалгуур болгож байна.


2020-2022 онд дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс ЭХ-ийн 18.6 дугаар зүйл ангиар шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлт:

График 3. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс Мөнгө угаах гэмт хэрэг (давхар зүйлчлэлтэй) шийдвэрлэсэн байдал



2020-2022 онд Нийслэлийн Давж заалдах шатны шүүхээс ЭХ-ийн 18.6 дугаар зүйл ангиар шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлт:


График 4. Нийслэлийн Давж заалдах шатны шүүхээс Мөнгө угаах гэмт хэрэг/давхар зүйлчлэлтэй/ шийдвэрлэсэн байдал





2020-2022 онд Хяналтын шатны шүүхээс ЭХ-ийн 18.6 дугаар зүйл ангиар шийдвэрлэсэн хэргийн тоон үзүүлэлт:

График 5. Хяналтын шатны шүүхээс Мөнгө угаах гэмт хэрэг/давхар зүйлчлэлтэй/ шийдвэрлэсэн байдал



Судалгааны хүрээнд 2020-2023 оны хооронд шийдвэрлэсэн Монгол улсын шүүхийн шийдвэрийн цахим сан болон УЕП-ын дэргэдэх эрүүгийн тусгай архивт буй нийт 230 гаруй шүүхийн шийдвэрийг судалсан болно. Эндээс анхан, давах хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргүүдийг сонгож, шийтгэх тогтоолуудыг түүвэрлэн авсан болно. Ийнхүү түүвэрлэхдээ дараах шалгуурыг тавьж шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ.

1. Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэсэн байх;
2. Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон байх;

3. Давж заалдах шат болон хяналтын шатны шүүхээр шийдвэрлэгдсэн байх;
4. Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход ач холбогдолтой байх.

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ мөнгө угаах гэмт хэргийн онцлог шинжийг агуулж байгаа эсэх, олон улсын эрх зүйн эх сурвалжтай нийцэж байгаа эсэх, хуулийг тайлбарлан хэрэглэхэд ялгаатай байдал байгаа эсэх, хүндрэл бэрхшээл үүсч буй эсэхийг тодорхойлохыг зорилоо. Энэ төрлийн гэмт хэргийг харьцуулан судлахын тулд БНСУ, БНХАУ, ОХУ, ХБНГУ, Шинэ Зеланд, Швед зэрэг улсуудын хууль тогтоомжийг судлав.

Судалгааны явцад шүүхийн шийдвэрүүдэд хийсэн дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа, онолын үзэл баримтлуудад үндэслэн судлаачийн зүгээс нэгдсэн дүгнэлт хийж, өөрсдийн зөвлөмжийг дэвшүүлэх замаар саналаа илэрхийлэхийг зорилоо.

**Тохиолдол 1. “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас чл хамааран хурааж улсын орлого болгоно.” (хэрэг №1-хавсралт)**

Нэр бүхий 16 яллагдагчид холбогдох бусдын мал болон эд хөрөнгийг хулгайлах, мөнгө угаах, бусдын эрүүл мэндэд хөнгөн, хүнд хохирол учруулсан гэмт хэргийг шүүх хэлэлцээд нэр бүхий 15 шүүгдэгчийг гэм буруутайд тооцож, Г.Д-г ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1.2-т заасан “хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан” үндэслэлээр түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, Хяналтын шатны шүүх шийтгэх тогтоол, магадлалын зарим заалтыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.



*Дүн шинжилгээ:*

Шүүгдэгч Г.Д нь бусдын хулгайлсан малд гарал үүслийн гэрчилгээ авч өгөх, малыг төхөөрөх, борлуулахад оролцож, Д.Б-аас бусад хохирогч нарын малыг борлуулсныг төлбөрт нийт 17,337,000 төгрөгийг Хаан банкин дах өөрийн ... дугаартай дансаар шилжүүлэн авсан нь тогтоогдсон тул шүүх Г.Д-г мөнгө угаах гэмт хэрэгт гэм буруутайд тооцсон боловч гэмт хэргийн улмаас бий болсон мөнгийг хурааж, улсын орлого болгож шийдвэрлээгүй байна.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9-д “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамааран шүүхийн шийдвэрээр хурааж улсын орлого болгоно” гэж заасан нь шүүхэд үүрэг болгосон, заавал хэрэглэх хэм хэмжээ юм. Гэтэл анхан шатны шүүх уг заалтыг хэрэглээгүй орхигдуулж шийдвэрлэсэн байна. Хуулийн дээрх заалт ямар нэгэн урьдчилсан нөхцөл, сонголтгүйгээр шууд хэрэглэгдэх, заавал биелэгдэх зохицуулалтын шинжтэй тул шүүх заавал хэрэгжүүлэх үүрэгтэй байна. Хяналтын шатны шүүх Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9-д заасны дагуу Г.Д-ийн эд хөрөнгийг хурааж, улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна.

ФАТФ-ын 40 зөвлөмжийн 3-р бүлгийн 4-д “Гэмт хэрэг үйлдэж олсон орлого, ашигласан хэрэгсэл, хөрөнгийг эрүүгийн шийтгэлгүй хураах арга хэмжээг улс орнууд боловсруулсан байвал зохино. Эсвэл хураах хөрөнгийг хууль ёсны гаралтай гэдгээ батлахыг гэмт хэрэгтнээс шаардах арга хэмжээг дотоодын хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулах хэрэгтэй” гэж заасан байна.

Энэхүү зөвлөмжийн дагуу улс орнууд холбогдох байгууллагад гэмт этгээдийн дараах хөрөнгийг хураах, царцаах, битүүмжлэх эрхийг олгохыг үүрэг болгосон байна. Үүнд: а) Угаасан өмч хөрөнгө, б) Мөнгө угаах болон суурь гэмт хэрэг үйлдэж олсон орлого, ашигласан буюу ашиглахаар зэхсэн хэрэгсэл, с) Терроризм, террорист үйлдэл, террорист бүлэглэлийг санхүүжүүлэхэд ашигласан, ашиглахаар

завдсан, эсвэл хуваарилсан орлогоос үүдэлтэй өм хөрөнгө эсвэл d) Дүйцэхүйц үнийн дүнтэй өмч хөрөнгө гэж заасан байна.

Тиймээс Хяналтын шатны шүүхээс шүүгдэгч Г.Д-ийн мөнгө угаах гэмт хэргийн улмаас олсон орлого нийт 17,337,000 төгрөгийг Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 9-д заасны дагуу хурааж улсын орлого болгохоор шийдвэрлэсэн нь дээрх ФАТФ-ийн зөвлөмжтэй нийцсэн байна.

**Тохиолдол 2. Өөрөө мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх нь:**

Нийтийн албан тушаалтан Б.Б жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн захирлаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Ш.Э-той урьдчилан үгсэн тохиролцож бүлэглэн, “О” компаниар дамжуулан Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас зээл авах шаардлага хангаагүй төслийг дэмжиж, 1,550,000,000 төгрөгийн санхүүжилтийг авч, зээлийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулан, өөртөө болон бусдад давуу байдал бий болгосон, мөн Б.Б, Ш.Э, Х.Т нар эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, өөртөө болон бусдад давуу байдал бий болгож буюу гэмт хэрэг үйлдэж олсон 1,550,000,000 төгрөгийг бусдад шилжүүлэх замаар авч, эзэмшиж, ашигласан ба хууль бусаар олсон мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах зорилгоор 2019 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хүртэл хугацаанд Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэрт баригдаж буй барилгын объект болгон хувиргаж, байнга тогтвортой мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн. Анхан шатны шүүх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.15 дугаар зүйлийн 2, 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-т заасныг баримтлан шүүгдэгч Б.Б, Ш.Э, Х.Т нарт холбогдох хэргийг бүхэлд нь гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, тэдгээрийг цагаатгаж, хэргийг хэрэг бүртгэлтэд буцааж шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүх цагаатгах тогтоолыг хэвээр үлдээж, Хяналтын шатны шүүх цагаатгах тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна.



*Дүн шинжилгээ:*

Анхан шатны шүүх шүүгдэгч Б.Б, Ш.Э, Х.Т нарт холбогдох хэргийг бүхэлд нь гэмт хэргийн шинжгүй гэж дүгнэн, хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн цагаатгах тогтоол ЭХХШТХ-ийн 36.9 дүгээр зүйлийн 1-д заасан шаардлагыг хангаагүй байна. Мөн хуулийн 39.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6-д зааснаар эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг ноцтой зөрчсөн байна.

Прокуророос шүүдэгч Б.Б-гийн албан тушаалын байдлаа урвуулан ашиглах болон мөнгө угаах гэмт хэрэгт хамтран оролцсон Ш.Э-ын үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 3.1 дүгээр зүйлийн 3, 3.2 дугаар зүйлийн 1-ийг тус тус журамлан тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 2 болон Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.8 дугаар зүйлийн 3, 3.1 дүгээр зүйлийн 3, 3.2 дугаар зүйлийн 1-ийг тус тус журамлан тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 2.2-т тус тус зааснаар яллах дүгнэлт үйлдсэнийг шүүх цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын Палермо конвенцын 6(1), (2)-т гэмт хэрэг үйлдэж үйлдэж олсон хөрөнгө, орлогыг угаах санаатай үйлдлийг заавал гэмт хэрэгт тооцохыг улс орнуудад үүрэг болгосон байна. Тухайлбал, Палермогийн конвенцын 2 дугаар зүйлд заасны дагуу ноцтой гэмт хэрэг, 5 дугаар зүйлд заасны дагуу зохион байгуулалттай гэмт бүлэг байгуулах, түүнд оролцох, 8 дугаар зүйлд заасны дагуу авлигын гэмт хэрэг, 23 дугаар зүйлд заасны дагуу шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах гэмт хэрэг болон зохион байгуулалттай гэмт бүлэг оролцсон бүх төрлийн гэмт хэргийг суурь гэмт хэрэгт заавал тооцно. Түүнчлэн Палермогийн конвенцоор хувь хүн, хуулийн этгээдэд хариуцлага заавал хүлээлгэхийг шаарддаг.

Мөнгө угаах гэмт хэрэг нь 1. Өөрөө угаах (self laundering), 2. Гуравдагч этгээд угаах (third party laundering), 3. Дангаар угаах (standalone laundering) гэсэн төрөлтэй. Тиймээс мөнгө угаах гэмт хэрэгт тооцох хууль бус хөрөнгө, мөнгө, орлогыг угаах аливаа арга,

төрөл, хэлбэрийг хуулиар зохицуулах шаардлагатай. Дангаар мөнгө угаах үйлдэлд суурь гэмт хэрэгт ял шийтгэгдсэн эсэхээс үл хамааран мөнгө угаах гэмт хэрэгт ял оногдуулах хууль эрх зүйн зохицуулалтыг бий болгох ёстой. ФАТФ-ын 40 зөвлөмжийн 3-т өөрөө мөнгө угаах үйлдлийг гэмт хэрэгт тооцохыг шаарддаг.

ЭХ-ийн 18.6 дугаар зүйлд заасан мөнгө угаах гэмт хэргийн шинжид мөнгө угаах гэмт хэргийг өөрөө угаах (self laundering), гуравдагч этгээд угаах (third party laundering), дангаар угаах (standalone laundering) төрлүүдийг хамруулж байгаа эсэхийг судлахын тулд хуулийн зүйл заалтын нэр томъёог задалж үзэх шаардлагатай.

ЭХ-ийн 18.6 дугаар зүйлийн 1-д заасан **“Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан”** гэх хэсгийг задалж үзвэл “гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон хууль бус хөрөнгө, мөнгө, орлого” гэсэн агуулга гарч байна. Харин суурь гэмт үйлдээд олж авсан хууль бус хөрөнгийг гэмт этгээд өөрөө өөрөөсөө авах боломжгүй буюу суурь гэмт хэрэг үйлдэхдээ аль хэдийн өөртөө авснаар суурь гэмт хэрэг төгсөх учир “гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон хууль бус хөрөнгө, мөнгө, орлогыг мэдсээр байж авсан” гэх агуулга бүхий үйлдэл нь **“гуравдагч этгээд мөнгө угаах”** үйлдэлд хамаарна. Гуравдагч этгээд ашиглах боломжтой буюу суурь гэмт хэрэг үйлдэж өөрийн эзэмшилдээ олж авсан этгээд өөрөө ашиглах, гуравдагч этгээдэд ашиглуулахаар дамжуулах боломжтой. Тиймээс “гэмт хэрэг үйлдсэний үр дүнд бий болсон хууль бус хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж ашигласан” гэх агуулга бүхий үйлдэл нь **“өөрөө мөнгө угаах”, “гуравдагч этгээд мөнгө угаах”** үйлдлийн аль алийг агуулсан байна.

Прокуророос шүүдэгч Б.Б-д албан тушаалын байдлаа урвуулан ашиглах болон мөнгө угаах гэмт хэрэгт ял сонгосон. ЭХ-ийн 18.6 дугаар зүйлийн 2-т заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг авч үзвэл “өөрөө мөнгө угаах” гэмт хэрэг байна. Өөрөөр хэлбэл Б.Б нь “нийтийн албан тушаалтан” тул хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй

гэмт хэрэгт холбогджээ. Уг хуулийн 2 дах хэсгийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд өөрөө мөнгө угаах үйлдэл, бусдаар мөнгө угаах үйлдлийг хамааруулах, суурь гэмт хэрэгт шийтгэгдсэн эсэхээс үл хамаарч Мөнгө угаах гэмт хэрэгт ял оногдуулах эрх зүйн зохицуулалт шаардлагатайг эндээс харж болно.

ЭХ-ийн 18.6 дугаар зүйлийн зохицуулалт ФАТФ-ын зөвлөмжид нийцсэн эсэх, мөнгө угаах гэмт хэргийн төрлүүдийг өөрийн улсын хууль тогтоомжид бүрэн тусгасан эсэх, мөнгө угаах гэмт хэргийн эрх зүйн орчин Монгол Улсад бүрдсэн эсэх талаас нь дүн шинжилгээг хийв.

### **Тохиолдол 3. Залилан мэхлэх гэмт хэрэг үйлдэх замаар мөнгө угаах хэрэгт үйлдэх**

Б.Э, Д.С нар бүлэглэн хуурч, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авч, их хэмжээний хохирол учруулж залилах гэмт хэрэг үйлдсэн, уг мөнгөн хөрөнгийн хууль бус эх үүсвэрийг нуун далдлах зорилгоор өөрчилж мөнгө угаах гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн гэмт хэрэгт холбогдсон.

Анхан шатны шүүх шүүгдэгч Д.С-д яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Д.С-г цагаатгаж, шүүгдэгч Б.Э-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 2.2-т зааснаар хуурч, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авч, их хэмжээний хохирол учруулж залилах гэмт хэрэг үйлдсэнд, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 2.2-т заасан гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж хууль бус эх үүсвэрийг нуун далдлах зорилгоор өөрчилж “мөнгө угаах” гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, Б.Э, Д.С нарт холбогдох хэргийг нэмэлтээр мөрдөн шалгуулахаар прокурорт буцааж, Хяналтын шатны шүүх магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.

*Дүн шинжилгээ:*

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 18.6 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 2.2-т Мөнгө угаах гэмт хэргийг “байнга тогтвортой үйлдэж” нөхцөлд хүндрүүлсэн. Шүүхийн шийтгэх тогтоолд “...Б.Э нь Д.С-ээс долоон удаагийн гүйлгээгээр шилжүүлэн авсан 20,006,375,060 төгрөгийг гэр бүлийн гишүүдийнхээ дансанд 1,441 удаагийн гүйлгээгээр шилжүүлж, мөн 190 удаагийн гүйлгээгээр “төсөлд хөрөнгө оруулах болон хувийн хэрэгцээндээ зарцуулсан” гэх үйл ажиллагаа...” гэж дүгнэжээ. Хэдийгээр Эрүүгийн хуульд Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг нэрлэн заагаагүй боловч хуульд мөнгө угаах гэмт хэргийн шинж, үе шатуудыг хангасан тохиолдолд гэмт хэрэгт тооцохоор хуульчлах шаардлага эндээс үүсэж байна.

Анхан шатны шүүх Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг оновчтой тодорхойлоогүй буюу суурь гэмт хэргээс хамаарч уг гэмт хэргийн шинжийг тодорхойлж байна. Өөрөөр хэлбэл залилан мэхлэх гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, мөнгө, орлого уу, мөнгө угаах гэмт хэрэг үйлдэх замаар бий болсон хөрөнгө, орлого уу гэдгийг тодорхойлоход хүндрэлтэй. Түүнчлэн мөнгө угаах гэмт хэргийг **байнга тогтвортой** үйлдсэн үү, нэг ерөнхий нэг зорилгод чиглэгдсэн ба хэд хэдэн удаагийн адил, төсөөтэй үйлдэл нь эцсийн дүндээ **нэгдмэл нэг хэрэг** үйлдсэн үү гэдгийг тодорхойлох шаардлагатай.

Олон улсын стандартад Мөнгө угаах гэмт хэргийн шинж, хамрах хүрээг тодорхойлохдоо “заавал хамруулах гэмт хэрэг”, босго аргачлалаар тогтоох гэмт хэргийн босго”, “гадаад улсад үйлдэгдсэн гэмт хэрэг нэгэн адил хамаарах” гэх мэт суурь зарчмыг заасан байдаг ч суурь гэмт хэргийн хүрээг илүү өргөн хүрээнд авч





үзэхийг үүрэг болгодог. Монгол Улсын хувьд суурь гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүх гэмт хэргийг хамруулсан нь хангалттай өргөн хүрээнд тодорхойлсон боловч суурь гэмт хэргийг боломжит өргөн хүрээнд авч үзэх босго аргачлал, босго аргачлалыг багтаасан холимог аргачлалыг зохицуулаагүйтэй холбоотой.

Тиймээс олон улсын түвшинд тогтсон өөрөө мөнгө угаах, гуравдагч этгээд мөнгө угаах, дангаар мөнгө угаах гэмт хэргийн шинжүүдийг зөв тодорхойлох, суурь гэмт хэрэгт ял шийтгэгдсэн эсэхээс үл хамааран мөнгө угаах гэмт хэрэгт ял шийтгэл оногдуулах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарчмыг анхаарах шаардлагатай. Анхан шатны шүүх Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн этгээд суурь гэмт хэрэг үйлдсэн нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл бий болох агуулгаар биш өөрөө мөнгө угаасан үйлдлийг зөв тодорхойлж, тогтоох ёстой гэж судлаачийн хувьд үзэж байна.

#### **Тохиолдол 4. Албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглах гэмт хэрэг үйлдэж мөнгө угаах**

Шүүгдэгч Ш.Б нь “Ж г” ХХК-ийн захирлаар ажиллаж байхдаа “С банк”-тэй 2009 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 36,000,000 америк доллар хүртэлх зээл олгох тухай, 2010 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 27,000,000 америк доллар хүртэлх зээл олгох тухай гэрээнүүд, тэдгээрт хамаарах нэмэлт гэрээ, нэмэлт өөрчлөлтийн баримт бичгийг боловсруулах, байгуулах явцдаа гэрээний батлан даалт, барьцааны үүрэгтэй холбоотой зарим баримт бичгийг тухайн үед “Э ү” ТӨҮГ-ын ерөнхий захирлаар ажиллаж байсан Ч.Г, хуулийн болон худалдааны хэлтсийн даргаар ажиллаж байсан Б.М, Г.А нарын нэр бүхий албан тушаалтнуудын эрх мэдлээ урвуулан ашигласан оролцоотойгоор үйлдэхдээ дээрх гэрээний батлан даалт, үүргийн гүйцэтгэлд хамаарах зарим баримт бичгийг өөрөө хуурамчаар үйлдсэн, дээр дурдсан гэрээнүүдийн дагуу 160,100,000 ам.долларын зээлийг авч ашигласан, улмаар гэрээний үүргийн гүйцэтгэлийн талаар үүссэн маргааны улмаас Олон улсын арбитрын шүүхийн шийдвэрээр 92,685,803 ам.долларын төлбөрийг

“Э ү” ТӨҮГ хариуцахаар болж, бусдын эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан.

Мөн тэрээр “Х банк” ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байхдаа 2010 онд иргэн Э.С-с зээлсэн 23,684,552.62 ам.доллар буюу 34,138,035,750.31 төгрөгийн гэрээний үнийн дүнг нэмэгдүүлж 56,500,000,000 төгрөгөөр тооцоо нийлж, уг төлбөртөө “О о г” ХХК-ийн 50 хувийн хувьцааг шилжүүлж хоорондын зээлийн төлбөр тооцоо дууссан атлаа, уг дуусгавар болсон гэрээний гүйцэтгэлийн бодит байдлыг нууж, Э.С, түүний эх Г.А нартай үгсэж хуйвалдаж, бүлэглэн “Төлбөрийн баталгаа”, “Банкны баталгааны гэрээ” зэрэг баримт бичгийг хуурамчаар нөхөн үйлдсэн, улмаар шүүхийн шийдвэрээр 51,596,943,659 төгрөгийг уг хуурамч баталгааны дагуу “Т банк” хариуцахаар болж, их хэмжээний хохирол учруулсан.

Түүнчлэн “О о г” ХХК-ийн хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар ажиллаж байхдаа “Ш г” ХХК-д 1,5 сая ам.долларын төлбөр хариуцах үүргийг шилжүүлэн хүлээн авсан атлаа, бодит байдлыг нууж, “Ш г” ХХК-ийн охин компани болох “Г ч” ХХК-д зээл олгож, хувьцааг нь шилжүүлэн авснаар төлбөрийг барагдуулна гэж төөрөгдөлд оруулан залилсан, түүнчлэн гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, мөнгийг ашигласан, тэдгээрийн эх үүсвэрийг нуусан гэмт хэрэг үйлджээ.

Анхан шатны шүүх шүүгдэгч Ш.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.3 дугаар зүйлийн 3.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг 17.3 дугаар зүйлийн 2.2-т зааснаар тус тус өөрчлөн зүйлчилж, Ш.Б-г хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан хувьдаа давуу байдал бий болгох зорилгоор албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан гэмт хэргийг зохион байгуулсан, урьдчилан үгсэж тохиролцсон, бүлэглэн гүйцэтгэсэн гэм буруутайд, тусгай зөвшөөрөл олгосон баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягтыг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг мэдсээр байж ашиглаж, бусдын эд хөрөнгөнд ноцтой хохирол учруулсан гэм буруутайд, **гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого**



**гэдгийг мэдсээр байж түүний авсан, ашигласан гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн**, албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн гэм буруутайд, хуурч, бодит байдлыг нуух, бусдыг төөрөгдөлд оруулах замаар өмчлөгчийн эд хөрөнгийг шилжүүлэн авч, их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага оногдуулж, Сингапур Улс болон Америкийн Нэгдсэн Улсад байрлах үл хөдлөх эд хөрөнгүүдийг хураан улсын орлого болгохоор шийдвэрлэсэн байна.

Давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолын зарим заалтыг өөрчилж, бусад заалтыг хэвээр үлдээж, Хяналтын шатны шүүх шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж шийдвэрлэжээ.

*Дүн шинжилгээ:*

Шүүгдэгч Ш.Б дээрх гэмт хэрэг үйлдэх замаар байгуулсан зээлийн гэрээний дагуу бодитоор шилжүүлэн авсан 137,9 сая америк доллар буюу 220,8 тэрбум төгрөгийг 2009 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн эзэмшиж, ашигласан, дээрх гэмт хэргийн улмаас олсон хууль бус орлогын шинж чанар, эс үүсвэрийг нуун далдлах зорилгоор гадаадын улс орнууд болон дотоодод үл хөдлөх хөрөнгө худалдаж авсан, түүнчлэн өөрийн өмчлөл, эзэмшилд байсан аж ахуйн нэгжийн хувьцаа, хөрөнгийг бусдад шилжүүлсэн гэмт хэргийг байнга, тогтвортой үйлдсэн болохыг анхан шатны шүүхээс тогтоогдсон гэж үзсэн.

Гэтэл давж заалдах шатны шүүхээс шүүгдэгч Ш.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.1 дүгээр зүйлийн 1-д заасан хэргийг, мөн хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 2.2-т заасан хэргийг, мөн хуулийн 18.6 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 2.2, 2.3-д заасан гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүний авсан, ашигласан гэмт хэргийг байнга тогтвортой үйлдсэн, албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн гэсэн гэмт хэргийг Эрүүгийн хэрэг

хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д зааснаар тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.

Давж заалдах шатны шүүхээс Ш.Б-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 21.1 дүгээр зүйлийн 1-д заасан хэргийг, мөн хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 2.2-т заасан хэргийг, мөн хуулийн 18.6 дугаар зүйлийн 2 дах хэсгийн 2.2, 2.3-д заасан гэмт хэргийг үйлдсэн шинжгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн боловч Магадлалын 10 дах заалтад “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ш.Б-гийн Сингапур Улсын 6 Martin place rendences 29-07, sangapord хаягт байрлах эд хөрөнгө, Сингапур Улсын 94 punggol central 01-33, sengaport 828724 хаягт байрлах эд хөрөнгө, Америкийн Нэгдсэн Улсын Шарлотте хотод харьяалагдах “63 Revenswood blvd 33954” тоот хаягт байрлах эд хөрөнгө, Флорида мужид Sweden ave nort port 8 FL34288 тоот хаягт байрлах үл хөдлөх эд хөрөнгийг хураан авч гэмт хэргийн улмаас хохирлыг нөхөн төлөхөд тус тус зарцуулсугай.” гэж дурьдсан байна.

Анхан шатны шүүхээс Ш.Б-г Эрүүгийн хуулийн тусгай ангийн 23.2 дугаар зүйлийн 2 дах хэсэг (Хуурамч барим бичиг үйлдэх, ашиглах), Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан (Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах) гэм хэрэгт гэм буруутайд тооцсон шийдвэрийг хэвээр үлдээсэн байна.

Давж заалдах шатны шүүх мөнгө угаах гэмт хэрэгт холбогдох мөнгөн хөрөнгийг эх үүсвэр хууль бус эсэхийг тогтоолгүйгээр мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэхгүй орхигдуулсан байна. Эрүүгийн хуульд зааснаар мөнгө угаах гэмт хэргийн гэмт үйлдлийг ерөнхий хоёр хэсэгт ангилж байна. Үүнд:

1. Гэмт хэргийн улмаас олсон орлого гэдгийг мэтсээр байж түүнийг хувьдаа авах, эзэмших, ашиглах;
2. Хууль бус мөнгөн хөрөнгийн эс үүсвэрийг нуун дарагдуулах зорилгоор тухайн хөрөнгийн хэлбэрийг өөрчлөх, тодорхой гүйлгээ хийх болон бусад үйлдэл хамаарна.



Шүүгдэгч Ш.Б-ийн үйлдэлд мөнгө угаах гэмт хэргийн зорилго, үе шат, хэлбэр, шинжүүд бүрэн агуулагдаж байна гэж судлаачийн хувьд үзэж байна. Шүүх шүүгдэгч Ш.Б-ээс шүүхийн шийдвэрээр хурааж авсан гадаад улсад байрлах өндөр үнэ бүхий үл хөдлөх хөрөнгийн эх үүсвэрийг шүүх зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл Ш.Б-ийн хууль бус мөнгөн хөрөнгө ямар замаар бий болсон, үндэслэлгүй хөрөнгөжсөн үйлдлийн талаар дүгнэх учиртай. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.12 дугаар зүйлийн 1-д заасан (Хуулийн этгээдийн эрх мэдлийг урвуулан ашиглах) гэмт хэргийн шинжээс илүүтэйгээр дээрх үйлдэлд ЭХ-ийн 18.6 дугаар зүйлийн 4-д заасан Мөнгө угаах гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн эсэхийг шалгаж, тогтооход анхаарах нь чухал юм.

Учир нь Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, Хахууль авах, Төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, Улсын нөөцийг хууль бусаар зарцуулах, үрэгдүүлэх, Төрийн өмчийн төсвийн бус хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах гэмт хэргүүд нь Мөнгө угаах, Үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэргийн суурь гэмт хэрэг болдог байна. Тиймээс суурь гэмт хэргийг үйлдсэн этгээд өөрөө мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн эсэхийг зөв тодорхойлох нь чухал ач холбогдолтой.

Мөнгө угаах гэмт хэрэг шийдвэрлэсэн хэргүүдэд суурь гэмт хэргийг үйлдсэн этгээдийг мөнгө угаах гэмт хэрэгт давхар зүйлчлэхгүй байх практик тогтжээ. Суурь гэмт хэрэг үйлдсэн этгээд нь өөрийн хууль бус мөнгөн хөрөнгийг угаасан тохиолдолд мөнгө угаах гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх практик бий болгох боломжтой.

**Тохиолдол 5. Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хувь хүнд үр дүнтэй, гаргасан үйлдэлд нь дүйцэхүйц, дахин үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.**

Шүүгдэгч Б.Б-г үргэлжилсэн үйлдлээр бусдын эд хөрөнгийг нууцаар, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан буюу хулгайлах,

хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдсэн, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдсэн, шүүгдэгч Б.М нь 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр “Теди” худалдааны төвийн гадна Б.Б-ийн хулгайлсан А.С-ын эзэмшлийн “Iphone 11 pro max” загварын гар утсыг гэмт хэргийн улмаас олсон болохыг мэдсээр байж худалдан авч, гар утсыг эзэмших, захиран зарцуулах эрхийг олж авсан гэмт хэрэг үйлджээ.

Анхан шатны шүүх шүүгдэгч Б.Б-г үргэлжилсэн үйлдлээр бусдын эд хөрөнгийг нууцаар, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан буюу хулгайлах гэмт хэрэг үйлдсэн, хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдсэн, хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол санаатай учруулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, шүүгдэгч Б.М-г гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө гэдгийг мэдсээр байж худалдан авч, эзэмших, захиран зарцуулах эрхийг олж авсан гэм буруутайд тус тус тооцож, эрүүгийн хариуцлага оногдуулсан байна.

Давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоолын зарим заалтыг өөрчилж, Хяналтын шатны шүүх шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

*Дүн шинжилгээ:*

Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сараас 1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр хуульчилсан байтал шүүгдэгч Б.М-д уг зүйл, хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ зорчих эрхийг хязгаарлах ялын хэмжээг тус зүйл, хэсэгт заагаагүй буюу 3 сарын хугацаагаар тогтоосон бөгөөд хуульд заасан ялын доод хэмжээнээс доогуур ял оногдуулсан үндэслэлээ тайлбарлаагүй, ялын хууль зүйн үндэслэл тодорхойгүй болжээ.

ФАТФ-ын 40 зөвлөмжийн 3 дугаар бүлэгт мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хүнд үр дүнтэй, гаргасан үйлдэлд нь дүйцэхүйц,



дахин үйлдэхээс сэргийлсэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхийг гишүүн улс орнуудад үүрэг болгосон. Гэтэл анхан шатны шүүхээс ЭХ-ийн 18.6 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулахдаа хуульд заасан хэмжээнээс доогуур ял шийтгэл оногдуулах нь дээрх олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгтэй зөрчилдөж байна.

Мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн этгээдэд ял шийтгэл оногдуулахдаа ахуйн шинжтэй үйлдэлд нь тохирсон гэж шүүх дүгнэсэн байх боловч уг гэмт хэргийн нийгэм, эдийн засагт үзүүлэх хор хөнөөл, хор уршиг, үр дагаврыг томоор харж, дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэхүйц байхад анхаарах шаардлагатай.

#### **Тохиолдол 6. Койн өмч хөрөнгөд хамаарахгүй.**

Б нь 2021 оны 11 дүгээр сард Т-г гэртээ байхад түүний DAX нэртэй криптовалютын биржид бүртгэлтэй хэтэвчинд койн авах зорилгоор Т-ийн мэйл хаягаар дамжин, DAX нэртэй криптовалютын биржид бүртгэлтэй хэтэвчинд нэвтэрсэн байдаг.

Улмаар нэг удаагийн нэвтрэх нэр, нууц үг хэтэвч эзэмшигчийн гар утсанд суулгасан Ard аппликейшнд ирснийг ашиглан мэдээллийг өөрчилж түүний DAX нэртэй криптовалютын биржид бүртгэлтэй 2.383.710 ширхэг IHC койныг, өөрийн Binance нэртэй криптовалютын бирж дэх хэтэвчиндээ шилжүүлж, USDT койн болгон хувиргаж, эзэмших гэмт хэрэг үйлдсэн.

Шүүхээс ЭХ-ийн 26.1.2-Цахим мэдээлэлд хууль бусаар халдах (хүндрүүлэх шинж) ЭХ-ийн 18.1. Мөнгө угаах гэмт хэрэг үзэж зүйлчилсэн байдаг. Энэ хэргийн тухайд суурь гэмт хэрэг нь цахим мэдээлэлд халдах гэмт хэрэг үү эсхүл хулгайлах гэмт хэрэг үү гэдэгт эргэлзээ үүссэн байдаг. Койн нь өмч хөрөнгөд хамаарахгүй тул тухайн хэргийг шийдвэрлэхдээ шүүх ЭХ-ийн 26.1.2-т зааснаар зүйлчилсэн байна.

## **ДҮГНЭЛТ**

Хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдалд заналхийлдэг нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдлийг гэмт хэрэгт тооцдог. Монгол Улсын хувьд мөнгө угаах гэмт хэргийн талаарх онолын ойлголт дутмаг, олон улсын байгууллагын хориг, хязгаарлалтаас үүдэлтэйгээр Эрүүгийн хууль тогтоомжийг шинэчлэн найруулж баталсаар байх боловч практикт төдийлөн оновчтой хэрэгжиж чадаагүй байна.

Судалгааны хүрээнд нийт 230 гаруй шүүхийн шийдвэрийг судлан, зохих шалгуурын дагуу 20 хэргийг түүвэрлэн судалж, түүнээс 6 хэргийг онцлон авч үзэв. Ингэхдээ гэмт хэргийн маргааны төрөл, хуулийг нэг мөр хэрэгжүүлэхэд гарч буй асуудал, хуулийг тайлбарлахад үүссэн зөрүүтэй ойлголтыг гаргаж тавихыг зорив.

ЭХ-ийн 18.6 дугаар зүйл “Мөнгө угаах” гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэхэд нэг талаас гэмт хэргийн шинжийг ойлгомжтой тодорхойлоогүй, нөгөө талаас хуулийн байгууллагын ажилтнуудын хууль хэрэглээний зөрүүтэй байдал энэ төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд хүндрэл, бэрхшээл, зүйлчлэлийн маргаан үүсгэж байна гэж дүгнэлээ.

Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг Эрүүгийн хуульд зөв томъёолоогүйгээс эрүүгийн хариуцлага гарцаагүй байх, гэмт үйлдэлд тохирсон ял шийтгэл оногдуулах, ял завшуулахгүй байх, гэмт хэргийн улмаас бусдад учруулсан хохирлоо төлж барагдуулах, ял шийтгэл нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг биелүүлж чадахгүй байна.

Үүнээс дүгнэхэд шүүх Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэхдээ хуулийг нэг мөр хэрэглэхгүй, ялгаатай тайлбарлан шийдвэр гаргаж байх бөгөөд энэ асуудлаар шүүхийн тодорхой практик тогтоогүй байна гэж судлаачийн хувьд үзлээ.

## САНАЛ

### Хуулийн зохицуулалтыг өөрчлөх хүрээнд:

- Мөнгө угаах гэмт хэрэг нь тодорхой үе шатыг дамжин хэрэгждэг, үйлдлийн арга, мөнгө угааж буй үйл ажиллагаа зэргийг нэгдмэл байдлаар тодорхойлсон олон улсын жишиг хандлага, мөнгө угаах гэмт хэргийн үндсэн шинжийг хууль тогтоогчоос анхаарч үзэлгүй орхигдуулан мөнгө угаах гэмт хэргийг хэт өргөн хүрээнд томъёолсноор практикт ойлгомжгүй, хүндрэлтэй байдлыг бий болгосон байна. Тиймээс Мөнгө угаах гэмт хэргийн хоёр гэмт үйлдлийг тус тусад нь салгаж хуульчлах шаардлагатай.
- Шүүхийн практикт мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дийлэнх хувь нь ахуйн хүрээнд үйлдэгдсэн гэмт хэргийг суурь гэмт хэрэгт тооцож шийдвэрлэжээ. Тэдгээр ахуйн хүрээнд үйлдэгдэж буй хулгайлах, дээрэмдэх, залилах гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгийг ашиглаж, эзэмшиж захиран зарцуулвал гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө борлуулах, авах гэмт хэрэг гэсэн зүйл ангиар зүйлчлэх нь зохимжтой. Иймд Эрүүгийн хуульд “Гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө борлуулах, авах” гэж нэмэлт өөрчлөлтийг оруулах санал гаргаж байна.
- Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд суурь гэмт хэргийг нэрлэн заах бус оногдуулах ял, эрүүгийн хариуцлага хийгээд гэмт хэргийн ангилал, шалгуурыг тогтоож, гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, мөнгө, орлогыг мөнгө угаах үе шатуудыг дамжиж угаасан үйлдлийг гэмт хэрэгт тооцож шийдвэрлэх боломжтой юм. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг боломжит өргөн хүрээнд авч үзэхдээ олон улсын стандартад заавал

байх гэмт хэргүүдийг хамруулж, босго аргачлалыг ашиглах шаардлагатай. Мөнгө угаах гэмт хэргийн суурь гэмт хэргийг хуульд тодорхойлолгүй, зөвхөн “Гэмт хэрэг” гэсэн томъёололоор хуульчилсан нь ахуйн хүрээнд хууль сайн хэрэгжиж байгаа мэт боловч Мөнгө угаах гэмт хэргийн үндсэн шинжийг хангасан тохиолдол цөөн байна. Өөрөөр хэлбэл мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй суурь гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдэхгүй байгаа нь асуудлын шалтгаан болж байна.

- Гэмт хэргийн улмаас бий болсон гадаад улсын нутаг дэвсгэрт байрлах хөрөнгийг хураан авч, улсын орлогод оруулахаар шүүх шийдвэрлэсэн байх боловч уг хөрөнгийг хэрхэн хураан авах, Монгол Улсад буцаан авчрах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэрхэн төлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг хуульд тодорхой тусгаагүй байна. Тиймээс гадаад улсад байгаа хууль бус үл хөдлөх хөрөнгө, банкны хадгаламж, бусад хөрөнгийг хураан авах, худалдан борлуулах, улсын орлогод оруулах тухай шүүхийн шийдвэр хэт ерөнхий хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, биелэгдэх боломжгүй нөхцөл байдалд хүрч байгааг зайлшгүй өөрчлөх нь зүйтэй.
- Сүүлийн жилүүдэд суурь гэмт хэрэг үйлдэж олсон хууль бус орлогыг гэмт этгээдүүд бэлэн мөнгө хэлбэрт байлгахаас зайлсхийж цахим хэлбэрт шилжүүлэх болсон. Гэтэл мөнгө угаах гэмт хэргийн хүрээнд халдлагад хамгийн эхэнд банк өртдөг. Тиймээс виртуал орчин дах эрх зүйн зохицуулалтыг шинээр болгох шаардлагатай. БНСУ-ын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулиар виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагааг хянах боломжтой болсон. Харин БНХАУ-д одоогоор виртуал хөрөнгийг үндэсний мөнгөн тэмдэгтэд тооцож, гүйлгээнд ашиглах боломжгүй тул гэмт хэрэгт тооцохгүй байна. Иймд виртуал хөрөнгөөр дамжуулан БНХАУ-ын зах зээлд гүйлгээнд оролцох боломжгүй. Манай улсын хувьд цаашид шинэ төрлийн гэмт хэргийн эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэрэгтэй байна.

- Эрүүгийн хуульд Мөнгө угаах гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг хамгийн багадаа 1 жил гэж хуульчилсан. Мөнгө угаах гэмт хэрэг нь олон үе шаттай, үндэстэн дамжин явагддаг, илрүүлэхэд төвөгтэй. Хөөн хэлэлцэх хугацааг багаар тогтоосноор мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, улмаар хангалттай хариуцлага тооцож чадахгүйгээс гэмт хэрэг гарах эрсдэл нэмэгдэж байна. Иймд энэхүү гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тус гэмт хэргийн шинж чанар, олон улсын конвенци, зөвлөмж, жишигт нийцүүлэн үндсэн гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг 12 болон түүнээс дээш жилээр нэмэгдүүлэх шаардлагатай байна.
- ЭХ-ийн 18.6 дугаар зүйлд “гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого” гэж заасан нь уг хуулийн 7.5 дугаар зүйлд заасан нэр томъёотой уялдахгүй байна. Учир нь “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого”-ыг хуульд тодорхой болгох шаардлагатай. ЭХ-д заасан “хууль бус хөрөнгө, орлого”, гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого”, “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж өөрөөр ойлголтууд бий. Гэтэл ЭХ-ийн 7.5 дугаар зүйлийн 2 дах хэсэгт “...гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж ойлгохоор заасан байна. Иймд хуулийн нэр томъёоны зөрүүтэй байдлыг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар засах нь зүйтэй.
- 2015 оны Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлд<sup>18</sup> гэм буруугийн шууд санаатай хэлбэрийг тогтоосон. Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого гэдгийг “мэдсээр байж” түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгдэнэ.<sup>19</sup> Гэтэл гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг мэдэх ёстой, эсхүл мэдэх боломжтой байсан боловч мэдэлгүйгээр мөнгө угаасан бол Эрүүгийн хуулийн 18.6 дугаар зүйлээр зүйлчлэх

боломжгүй. Нарийн зохион байгуулалт бүхий мөнгө угаах гэмт хэргийн субъектив талыг тогтооход хүндрэлтэй байдаг тул холбогдох олон улсын конвенцууд “*хайхрамжгүй хандах*” гэм буруугийн хэлбэрийг тогтоож болохоор зохицуулсан. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар банк, банк бус санхүүгийн байгууллага зэрэг олон субъект хууль бус гүйлгээг мэдээлэх үүрэг хүлээдэг. Бусад улс орнуудад орлогын хууль бус эх үүсвэрийг мэдэх боломжтой байсан ч мэдээгүй этгээд эрүүгийн хариуцлага хүлээдэг. Тиймээс Мөнгө угаах гэмт хэрэгт гэм буруугийн болгоомжгүй хэлбэрийг хуульчлах боломжтой юм.

### **Шүүхийн практик тогтоох, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хүрээнд:**

Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэхэд шүүхэд нэг мөр тогтсон практик байхгүйгээс өөрөөр тайлбарлан хэрэглэж байна. Анхан, давах, хяналтын шатны шүүх, орон нутаг, дүүргийн шүүх, хуулийн байгууллага, ажилтнууд хууль хэрэглээний нэгдмэл байдалд хүрэхгүй байгаа нь нэг талаас хууль эрх зүйн орчноос хамаарч байна. Гэвч нөгөө талаас Эрүүгийн хуулийн суурь зарчим, хэм хэмжээ, онолын ойлголт, нэгдэн орсон олон улсын конвенци, стандартыг хуульчид хууль тайлбарлан хэрэглэхдээ зайлшгүй анхаарах хэрэгтэй.

Мөн УДШ-ийн тодорхой төрлийн гэмт хэргийг шийдвэрлэхэд хуулийг зөв ойлгож хэрэглэх талаар гаргасан тайлбар, хэрэг маргааны шийдвэрлэсэн хууль, эрх зүйн үндэслэл, дүгнэлтийг судалж, практикт жишиг тогтоох замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтоох боломжтой гэж үзэж байна.

Нийгмийн хөгжлийн хурдтай зэрэгцээд мөнгө угаах гэмт хэрэг үйлдэж буй этгээдүүд бүлэг, зохион байгуулалт нь улам нарийсаж гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэр боловсронгуй болж техник, технологийн дэвшлийн ашиглаж, гэмт хэргийн улмаас бий болсон хөрөнгө, орлогоо улс дамжуулан шилжүүлэх хандлага ажиглагдаж

<sup>18</sup> Эрүүгийн хууль 2015, 18.6 дугаар зүйл. <https://legalinfo.mn/mn/detail/11634>

<sup>19</sup> С.Гантулга, Б.Энхболд, Эрүүгийн эрх зүйн Тусгай анги /Сурах бичиг/, УБ., 2020 он, 194 дэх тал.

байна. Тиймээс энэ чиглэлд хуулийн байгууллагын албан хаагч мэргэшүүлэх, чадавхжуулан сургах нь ач холбогдолтой.

### ЗӨВЛӨМЖ

1. Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссанаас үл хамаарч гэмт хэргийн улмаас бий болсон хууль бус хөрөнгө, мөнгө, орлогыг заавал хурааж, улсын орлого болгож шийдвэрлэх;
2. Мөнгө угаах арга, хэлбэр, үе шатыг зөв тодорхойлж, зүйлчлэх;
3. Хуулийг зөв ойлгож хэрэглэх талаар гаргасан тайлбар, хэрэг маргааны шийдвэрлэсэн хууль, эрх зүйн үндэслэл, дүгнэлт, шүүхийн практикыг судлах;
4. Мөнгө угаах гэмт хэргийн өндөр эрсдэлтэй суурь гэмт хэргийг шийдвэрлэхдээ хууль бус хөрөнгийн эх үүсвэрийг тараан байршуулсан, нуун далдалсан, нэгтгэсэн, байдлыг шалгаж тогтоох;
5. Мөнгө угаах гэмт хэргийг шийдвэрлэх явцад Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй этгээд үүргээ хэрэгжүүлсэн байдалд үнэлэлт өгч байх;
6. Нийгмийн хор аюул ихтэй, хар тамхи, байгаль орчны эсрэг гэмт хэргүүд, хүн худалдаалах, мансууруулах бодисын худалдаа гэх мэт гэмт хэргүүдийг илрүүлж, түүнээс олсон хөрөнгө, мөнгийг угааж буй эсэхийг олж тогтооход анхаарах.

### АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

#### Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Эрүүгийн хууль (1993, 2002, 2015)
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
4. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2006
5. Зөрчлийн тухай хууль, 2017

#### Олон улсын гэрээ

1. ФАТФ-ын 40 зөвлөмж
2. Авлигын эсрэг НҮБ-ын 20023 оны конвенц
3. Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын 2000 оны конвенц
4. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын Венийн конвенц
5. АНДМУТБ-аас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоонд хийсэн Харилцан үнэлгээний тайлан, 2007
6. АНДМУТБ-аас Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх Монгол Улсын тогтолцоонд хийсэн Харилцан үнэлгээний тайлан, 2017
7. Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх Үндэсний эрсдэлийн үнэлгээний тайлан, 2016

### Сурах бичиг, бүтээл

1. Монгол хэлний их тайлбар толь болон Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966
2. А.Батсайхан, Үндэстэн дамнасан гэмт хэрэг ба монгол улсын үндэсний аюулгүй байдлын тулгамдсан асуудал
3. Т.Золбоо, Сургалтын эрүүгийн хууль, УБ., 2023
4. Ж.Эрдэнэбулган, Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль, УБ., 2021
5. Д.Баярсайхан, Харьцуулсан эрүүгийн эрх зүй, УБ., 2014
6. С.Гантулга, Б.Энхболд нар, Эрүүгийн эрх зүй: тусгай анги. УБ., 2020
7. Г.Гантөмөр, Эрүүгийн эрх зүй, Ерөнхий анги, УБ., 2020
8. Л.Галбаатар, Монгол Улсад мөнгө угаах гэмт хэргийн шийдвэрлэж буй шүүхийн практик. Шүүх эрх мэдэл сэтгүүл, УБ., 2018, №3
9. С.Нарангэрэл. Монгол Улсын Хууль зүйн нэвтэрхий толь, УБ., 2021
10. С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй
11. Эдийн засгийн гэмт хэрэг, УБ., 2017
12. УДШ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ., 2013
13. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар, “Эдийн засгийн гэмт хэрэг II”, УБ., 2018, 194 дэх тал
14. Монгол банк, Санхүүгийн боловсрол, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь УБ., 2020
15. Йорас Ферверда (Joras Ferwerda) “Мөнгө угаах гэмт хэргийн нөлөөлөл”, Мөнгө угаах гэмт хэргийн судалгааны гарын авлага, 2013 он, 33 дах тал

16. Санхүүгийн зохицуулах хороо. Мөнгө угаах гэж юу вэ?, Гарын авлага, 2019 он, 3 тал
17. Досжин Б.Мөнгө угаах гэмт хэргийн шинжийг харьцуулан судлах нь УБ., 2018, 4-5 дах тал
18. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газар. “Эдийн засгийн гэмт хэрэг II”, 2018 он, 195 дах тал
19. Монгол Улсын Гадаад харилцааны яам, Монгол улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний жагсаалт, 2015 оны 12 сар, <http://www.mfa.gov.mn/>
20. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудал, Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, УБ., 2018 он, 12 дах тал.
21. “Монгол банкны санхүүгийн мэдээллийн албаны дарга Х.Батчулууны илтгэл, “Монгол улсын мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцоо, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох зарчим асуудал”.

### Цахим сайт

1. Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн сан /shuukh.mn/
2. History of Anti-Money Laundering Laws, Money Laundering Control act (1986), <https://www.fincen.gov/history-anti-money-laundering-laws>
3. [www.mongolbank.mn/listcma.asp?id=3](http://www.mongolbank.mn/listcma.asp?id=3) Санхүүгийн зохицуулах хороо. Мөнгө угаах гэж юу вэ?, Гарын авлага, 2019 он, 3 тал
4. <https://www.unodc.org/en/money-laundering/overview.html> 2023.04.29
5. Монгол Банк. “Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдэлийн үнэлгээ”, УБ., 2016 он, 44 дэх тал ([https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/20161025\\_risk\\_assessment.pdf](https://www.mongolbank.mn/file/files/documents/cma/20161025_risk_assessment.pdf) 2023 оны 5 сарын 1-ний өдрийн тандалт



# 2

## ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭСРЭГ ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### СУДЛААЧДЫН ТАНИЛЦУУЛГА



#### **БИРААГИЙН ОДОНГЭРЭЛ (PH.D)**

Б.Одонгэрэл МУИС-ийн Хууль зүйн сургуулийг эрх зүйч мэргэжлээр бакалавр, магистр зэрэгтэй төгссөн. 2011 онд Япон улсын Кюшүгийн их сургуульд хууль зүйн магистрын зэрэг хамгаалсан. 2020 онд “Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдвээр хууль зүйн ухааны докторын зэрэг хамгаалсан. 2005-2015 онд ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, бодлогын ахлах судлаачаар, 2015-2019 онд ШЕЗ-ийн Сургалтын хэлтсийн дарга, Хүний нөөцийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах хэлтсийн даргаар тус тус ажиллаж байсан.

2019 оноос одоог хүртэл СИТИ Их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирлаар ажиллаж байна. МХХ-ны гишүүн, МӨХ-ны гишүүн өмгөөлөгч.

Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүй, криминологи, харьцуулсан эрх зүйн чиглэлээр сургалт, судалгааны ажил эрхлэн явуулж байна. Судалгааны чиглэлээр 19 жил ажиллахдаа ном, гарын авлага 5, нэг сэдэвт бүтээл 1, бие даасан, хамтарсан 30 гаруй судалгааны ажил, 20 гаруй өгүүлэл, нийтлэл бичиж, 3 хуулийн төсөлд санал өгсөн. 20 гаруй эрх зүйн магистр, бакалаврын ажил удирдаж, 1 докторын ажилд албан ёсны шүүмжлэгчээр ажилласан.

Судлаач

Б.Одонгэрэл

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГ.....	58
ГРАФИК, ХҮСНЭГГИЙН ЖАГСААЛТ.....	59
УДИРТГАЛ.....	60

### НЭГ. ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧНЫ ЭСРЭГ ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ.....

1.1. Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйл. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг.....	66
1.2. Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйл. Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг.....	68
1.3. Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг.....	70

### ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТООН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ.....

2.1. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг шийдвэрлэсэн байдал .....	76
--	----

### ГУРАВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ .....

3.1. Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйл “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн шинжилгээ.....	80
3.1. Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн “Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах” гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн шинжилгээ .....	92
3.3. Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйл “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэргийн шүүхийн шийдвэрийн шинжилгээ .....	104

### ДҮГНЭЛТ.....

### САНАЛ.....

### АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....



## ТОВЧИЛСОН ҮГ

ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
UNODC	United Nations Office on Drugs and Crime
IDLO	International Development Law Organization

## ГРАФИК, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

График 1. 2018-2022 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн тооны өсөлт .....	73
График 2. Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийн өсөлт, бууралт (2018-2022 он) .....	74
График 3. Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлын хэмжээ (2018-2022) .....	77
Хүснэгт 1. Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлийн 3 дах хэсэгт заасан гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд	77

## УДИРТГАЛ

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг (Environmental crime) нь олон улсад учруулж буй хохирлын хэмжээгээрээ хууль бус эмийн худалдаа, хуурамч мөнгө үйлдвэрлэх, хүн худалдаалах гэсэн гэмт хэргүүдийн араас дөрөвдүгээрт бичигддэг. Жилд энэ төрлийн гэмт хэргийн улмаас дунджаар 110-281 тэрбум долларын хохирол учирдаг.<sup>1</sup> Хохирогчгүй гэгдэх энэ төрлийн гэмт хэрэг нь төрийн зүгээс анхаарах асуудлын жагсаалтын дээгүүр байр суурь эзэлдэггүй ч нийгэмд маш их хохирол учруулдгийг нь UNODC-ын тайланд дурджээ.<sup>2</sup> Тухайлбал, хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн улмаас дэлхий даяар ойгүйжилт нэмэгдэж байна.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 24.1-24.9 дүгээр зүйл хүртэлх нийт 9 гэмт хэргийг хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлагыг хувь хүн, хуулийн этгээдэд хүлээлгэж байна. Улсын хэмжээнд гэмт хэргийн тоо өсөн нэмэгдэж байгаатай адил хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа нэмэгдсээр байна. Тухайлбал, 2018 онд 130, 2019 онд 213, 2020 онд 274, 2021 онд 333, 2022 онд 422 хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгджээ.<sup>3</sup>

Энэхүү сүүлийн жилүүдэд өндөр өсөлттэй байгаа хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх,

<sup>1</sup> FATF President Marcus Pleyer Message to the G7 on tackling environmental crime <https://www.fatf-gafi.org/en/publications/Environmentalcrime/Environmental-crime.html>

<sup>2</sup> Environmental Investigation Agency, Environmental Crime A Threat to Our Future, 2008 [https://www.unodc.org/documents/NGO/EIA\\_Ecocrime\\_report\\_0908\\_final\\_draft\\_low.pdf](https://www.unodc.org/documents/NGO/EIA_Ecocrime_report_0908_final_draft_low.pdf)

<sup>3</sup> ШЕЗ-ийн Шүүн таслах ажиллагааны тайлан, 2018-2022 он

тэр тусмаа энэ төрлийн гэмт хэргээс хамгийн ихээр үйлдэгддэг 24.2, 24.3 болон 24.6 дугаар зүйлд хамаарагдах 3 төрлийн гэмт хэргийн шийдвэрлэлтийг энэхүү судалгааны хүрээнд авч үзлээ. Жишээлбэл, хүрээлэн байгаа орчны эсрэг нийт гэмт хэргийн 26-38 хувийг (624) хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг эзэлжээ.

Түүнчлэн дээрх 3 төрлийн гэмт хэргийн эзлэх жин, өсөлт бууралтаас гадна эдгээр 3 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр Эрүүгийн хуульд тусгагдсан юм. Хуулийн этгээдийн зүгээс үйлдэгдэх гэмт хэргийн тоо цөөн хэдий ч учруулж буй хохирол, хор уршгийн хувьд асар их болж өссөөр байна. Тухайлбал, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн улмаас учирч буй хохирлын хэмжээ нь нэг жилд 14 тэрбум байгаа бол үүнээс хуулийн этгээдийн учруулсан хохирол 10 тэрбум, хувь хүний учруулсан хохирол нь 4 тэрбум байна.<sup>4</sup> Мөн хохирол нөхөн төлүүлсэн байдлыг судлахад 4 тэрбум төгрөгийн хохирол төлүүлсний 3.4 тэрбум төгрөгийн хохирлыг хуулийн этгээдээс төлүүлжээ. Үүнээс үзэхэд хуулийн этгээд үйлдэх гэмт хэрэг нийт гэмт хэрэгт маш бага хувь эзэлж байгаа боловч учруулсан хохирлоороо нийт хэрэгтэй харьцуулахад хохирлын 72 хувийг эзэлж байна. Энэ нь хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэгт хуулийн этгээд онцгой субъект бөгөөд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатайг харуулж байна.

Энэхүү судалгаа нь хүрээлэн буй орчны эсрэг зарим төрлийн гэмт хэргүүдийг буюу Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлийн 3 дах хэсэгт зааснаар хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх бөгөөд ингэхдээ тухайн шийдвэрүүдтэй холбоотой эрх зүйн асуудлыг тодруулах, ялангуяа хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаа онцлогийг илрүүлэх, шүүхийн практикийг тогтоох, шүүхийн шийдвэр боловсруулахад анхаарах асуудлыг дэвшүүлэх, улмаар эрүүгийн эрх зүйн хөгжилд

<sup>4</sup> ШЕЗ-ийн Шүүн таслах ажиллагааны тайлан 2022 он



хувь нэмрээ оруулахад оршино. Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтуудыг дэвшүүлж уг судалгааг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг, Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг, Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг шийдвэрлэж буй тоон мэдээнд дүн шинжилгээ хийх;
2. Гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдийг тогтоож буй онцлог, тус гэмт хэргийг үйлдсэн хувь хүнд хамтад нь ял оногдуулсан байдал буюу давхар хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалтад дүгнэлт хийх;
3. Дээрх 3 төрлийн гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ оногдуулж буй ялын хэмжээ, ялгамжтай байдал, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийн нөхөн төлөлтөд дүн шинжилгээ хийх;
4. Цаашид дээрх төрлийн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэхэд анхаарах асуудлыг тодорхойлж, хууль хэрэглээний болон онолын дүгнэлт хийх зэрэг болно.

Судалгааны сэдвийг тодорхойлохдоо дээр өгүүлснээр нэгдүгээрт, 2018-2021 оны шүүн таслан ажиллагааны тайланд дээрх 3 төрлийн гэмт хэрэг нийт үйлдэгдсэн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн 80 хувийг эзэлсэн; хоёрдугаарт, дээрх гэмт хэргүүд нь Эрүүгийн хуулиар хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалттай хүрээлэн буй орчны гэмт хэрэг; гуравдугаарт, хуулийн этгээд үйлдсэн гэмт хэрэг нийт үйлдэгдсэн гэмт хэргийн маш бага хувийг эзэлж байгаа хэдий ч учруулж буй хохирлын 72 хувийг эзэлж байгааг нь анхаарал татаж байна.

Түүнчлэн эдгээр төрлийн гэмт хэргийг зүйчлэл буюу гэмт хэрэг, зөрчлийг ялгах, гэмт хэргийн хохирол, хор уршгийг үнэлж тогтоох байдал хангалтгүй, албадлагын арга хэмжээг эрүүгийн хариуцлага оногдуулахдаа хэрэглэдэггүй зэрэг асуудлууд тулгамдаж байна. Энэхүү судалгаагаар дээрх асуудлыг шүүх хэрхэн шийдвэрлэж

байгааг судалж улмаар ямар зохицуулалт, практик тогтоох талаар санал зөвлөмж гаргах нь өндөр ач холбогдолтой.

Энэхүү судалгааг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс шийдвэрлэсэн хэргийн хүрээнд Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) -д байршуулсан шийдвэрт үндэслэн хийхээр төлөвлөсөн хэдий ч зөвхөн анхан шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийв. Учир нь [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх, харьцуулан дүгнэх хэмжээний судалгааны эх сурвалж олдоогүйг энд дурдах нь зүйтэй болов уу.

Судалгааг ШЕЗ-өөс баталсан “Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал”, “Олон улсын хөгжлийн эрх зүйн байгууллагын зөвлөмж” (IDLO) зэрэгт үндэслэн судлаачийн өөрийн боловсруулсан онцлог бүхий аргачлалаар хийж гүйцэтгэв. Түүнчлэн баримт бичгийн шинжилгээний аргаар судалгаанд холбогдох баримт бичгүүдэд буюу 2018-2021 оны хооронд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг шүүхээр хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн дүн мэдээ, түүний өсөлт бууралт, шийдвэрийн онцлогийг мөн авч үзлээ.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгаа, ялангуяа хуулийн этгээдийн зүгээс үйлдсэн хэргийн онцлогийг тодорхойлсон судалгаа, бүтээл одоогоор цөөн байна. “Хууль бус ашигт малтмалыг хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн талаар доктор Б.Цогтбаатарын докторын диссертацийн ажил байгаа ч энэ нь шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгааг агуулаагүй юм. Түүнчлэн доктор Б.Одонгэрэл Нээлттэй нийгэм форумын захиалгаар “Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тулгамдаж буй асуудал” бодлогын судалгааг 2022 онд гүйцэтгэсэн хэдий ч хүрээлэн буй орчны гэмт хэргийг онцгойлон авч үзэж, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийгээгүйгээрээ онцлогтой юм.



## НЭГ. ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ЭСРЭГ ЗАРИМ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРГҮҮДИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Хүн төрөлхтний оршин тогтнох өлгий болсон байгаль дэлхийгээ танин мэдэж, түүний нөөц баялгийг зүй зохистой ашиглахын зэрэгцээ нөхөн сэргээж хайрлан хамгаалах нь дэлхий нийтийн амин чухал асуудлын нэг билээ. Монгол Улс уул уурхайн олборлолт хийж эхэлснээс хойш байгаль орчинд ноцтой хохирол учруулсан гэмт хэрэг олноор үйлдэгдэх болсон. Хууль бус уул уурхайг ногоон түмпэн үүрсэн, хүрз жоотуу барьсан нинжагаар төсөөлдөг нөхцөл байдал сүүлийн арав гаруй жилийн хугацаанд нэлээдгүй өөрчлөгджээ. Тодруулбал, энэ төрлийн гэмт хэргийг хүчин чадал өндөртэй экскаватор, ковш, ачигч ашиглан, зохион байгуулалттай бүлэг, хуулийн этгээдүүд ихээр үйлдэж байна. Шинжлэх ухаан, техник, технологи эрчимтэй хөгжиж, үйлдвэржилт, аж ахуй эрхлэлт эрчимжиж, хотжилт, хүн амын төвлөрөл ихсэж буй өнөө үед байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулах, сөргөөр нөлөөлөх хор уршиг гарсаар байгаа нь хүрээлэн буй орчин, түүний зохицолт байдлыг хангах, хамгаалах нь тулгамдсан асуудал болсныг илтгэж байна.

Экологийн цагдаагийн албаны мэдээллээр ашигт малтмал хууль бусаар хайх, ашиглах, олборлох гэмт хэрэгт олон тооны хуулийн этгээд шалгагдсан, мөн шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн 86 хувь нь өндөр хүчин чадалтай машин механизм ашигласан байгаа нь нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдсөнийг харуулж байна. Хууль бус уул уурхайг дагалдан бусад төрлийн гэмт хэрэг үйлдэгдэх, хүний эрх зөрчигдөх, амь нас, эрүүл мэнд хохирох, байгаль орчин сүйдэх,

бохирдох сөрөг үр дагавар үүсдэг. Хариуцлагагүй уул уурхайн компаниудын улмаас Монгол Улсад 20 гаруй мянган га газар нөхөн сэргээгдээгүй байгаа бол хууль бус уул уурхайн улмаас 8 орчим мянган га газар буюу эрүүл хөрс, гол горхи, ой мод сүйдсэн тухай тоон мэдээ байна.

Өнөөдөр дэлхийд ашиглагдаж байгаа 11 сая орчим нэр төрлийн химийн бодисоос 10 мянга гаруй нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа эсэхэд эрсдэлийн үнэлгээ хийгдсэн. 50 жилийн өмнө хүн төрөлхтөн жилд нэг сая тонн химийн бодис үйлдвэрлэж байсан бол өдгөө энэ нь 400 сая тонн болтлоо нэмэгджээ. Мөн 100 орчим мянган нэр төрлийн химийн бодисыг улс хооронд худалдаалж, жилдээ 1000 орчим нэр төрлийн химийн бодисыг шинээр нээж байна. Түүнчлэн иргэд болон гар аргаар алт олборлогчид алтны баяжмалтай шороог химийн хорт бодис болох мөнгөн ус ашиглан угаах, химийн хорт, аюултай бодисыг тээврийн хэрэгсэлд нуун хилээр оруулж ирэхийг завдсан тохиолдлууд бий.

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг нь дэлхий дахинд ойгүйжилт, цөлжилтийг дагуулж буй өнөө үед Монгол Улсад ч энэ гэмт хэргийн улмаас учирч буй хохирол, хор уршиг нэмэгдсээр байна. Монгол орны хувьд нутаг дэвсгэрийн дөнгөж 8 орчим хувь нь ойгоор бүрхэгдсэн бөгөөд ихэвчлэн нутгийн хойд хэсгээр тархсан байдаг. Гэтэл энэ төрлийн гэмт хэрэг нь манай улсад хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн ихэнх хувийг эзэлж байна.

Хүрээлэн буй орчны эсрэг зарим төрлийн гэмт хэргүүдийг (Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйл) шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхийн өмнө эрх зүйн зохицуулалт, түүний зарим онцлогийн талаар товч авч үзье.

### 1.1. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 24.2 ДУГААР ЗҮЙЛ. ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ, ОЛБОРЛОХ ГЭМТ ХЭРЭГ

Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа хадгалагдаж байгаа ашигт малтмал нь төрийн өмч тул түүнийг эрж хайх, ашиглах, олборлох үйл ажиллагаа нь зөвхөн төрийн эрх бүхий байгууллагаас олгосон эрх буюу тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн явуулдаг тусгайлсан зохицуулалттай харилцаа юм. Иймд хувь хүн, хуулийн этгээд хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох нь Монгол Улсад Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг юм.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин, байгаль хамгаалах болон ашигт малтмал хайх, ашиглах, олборлох журамд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуульд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл. Энэ гэмт хэргийн объект нь байгаль орчин, байгаль хамгаалах болон ашигт малтмалын эрэл хайгуул хийх, ашиглах, олборлох журам бөгөөд халдлагын зүйл нь халдагдсан газар, газрын хэвлий, хууль бусаар олборлогдсон ашигт малтмал юм. “Ашигт малтмал” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсэж бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг хэлнэ.<sup>5</sup>

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн объектив тал нь эрх бүхий байгууллагаас олгосон эрх буюу тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан идэвхтэй үйлдэл бөгөөд хохирол учруулсан болон ашиг олсон байхыг шаардахгүй.

<sup>5</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэг, 2006 он

Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “...ашигт малтмал... гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсэж бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг...”, 4.1.6-д “...ашигт малтмал хайх...” гэж эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг...” гэж, 4.1.15-д “...хайгуулын тусгай зөвшөөрөл...” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олгосон баримт бичгийг...” гэж тус тус заасан байна.<sup>6</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна...”, 6 дугаар зүйлийн 2 дах хэсэгт “...Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн...”, Ашигт малтмалын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “... Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн...” гэж хуульчилсан бөгөөд 1992 оны Үндсэн хуулиараа Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмалыг төр өмчдөө авсан байдаг. Монгол Улсын газрын гадаргуу болон хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмалд хэн ч хууль бусаар халдах ёсгүй.

<sup>6</sup> Ашигт малтмалын тухай хууль, 2006 он





## 1.2. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 24.3 ДУГААР ЗҮЙЛ. ХИМИЙН ХОРТ АЮУЛТАЙ БОДИСЫГ ХУУЛЬ БУСААР ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг гэдэг нь байгаль орчин, байгаль хамгаалах болон химийн хорт, аюултай бодисыг үйлдвэрлэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, ашиглах журамд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм. Энэ гэмт хэргийн объект нь байгаль орчин, байгаль хамгаалах болон химийн хорт, аюултай бодисыг үйлдвэрлэх, хадгалах, хамгаалах, тээвэрлэх, ашиглах талаар тогтоосон хууль тогтоомж, журам байна.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу олгоно.”, 8.3-д “Химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийн нэгдлийг химийн зэвсгийн болон хорлон сүйтгэх үйл ажиллагааны зориулалтаар экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, худалдан авах, ашиглах болон бусдад дамжуулахыг хориглоно.”, 20.1-д “Химийн хорт болон аюултай бодистой холбогдох хууль тогтоомж зөрчиж, хууль бус үйл ажиллагаа явуулсны улмаас бусдын эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтан, эд хөрөнгөд учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ” гэж тус тус заасан.<sup>7</sup>

Гэмт хэргийн халдлагын зүйл нь химийн хорт, аюултай бодис байх ба химийн хорт бодис гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх

<sup>7</sup> Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2006 он

үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.<sup>8</sup> Химийн аюултай бодис гэж тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.<sup>9</sup> Объектив тал нь химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар улсын хил нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан идэвхтэй үйлдэл байна. Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийн үндсэн шинж нь байгаль орчин, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан байхыг шаардахгүй.

Зөрчлийн тухайд заасан зөрчил нь Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд заасны дагуу тусгайлан авсан зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулахдаа химийн хорт болон аюултай бодистой харьцах талаар тогтоосон журам (захиргааны хэм хэмжээний акт) зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй байна. Энэхүү тогтоосон журам зөрчих гэдэг нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, дамжуулах, ашиглах зөвшөөрөл авсан боловч тухайн бодистой харьцах талаар тогтоосон журмыг зөрчсөн үйлдэл байна.

Харин Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг нь Монгол Улсын хууль, химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, захиргааны хэм хэмжээний актаар хориглосон химийн хорт болон аюултай бодисыг улсын хилээр нэвтрүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй байна. Мөн гэмт хэргийн тухайд хуульд заасан ямар нэгэн зөвшөөрөл авалгүйгээр хийж буй хууль бус үйлдэл байна.

<sup>8</sup> Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйл, 3.1.1 дэх хэсэг, 2006 он

<sup>9</sup> Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дах хэсэг, 2006 он



### 1.3. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 24.6 ДУГААР ЗҮЙЛ. ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ ГЭМТ ХЭРЭГ

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг нь байгаль орчин, ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглахтай холбоотой харилцаанд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд хуульчлан тодорхойлж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нийгэмд аюултай үйлдэл юм. Тус гэмт хэргийн объект нь байгаль орчин, ойг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцаа, журам байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 1-д “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна”, 2-т “Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн.” гэж заасан.

Халдлагын зүйл нь ой мод, мод, модон материал байх ба мод, модон материал гэж ойгоос бэлтгэсэн мод, гуалин, шургааг, дүнз, зүсмэл материал, түлээг ойлгоно.<sup>10</sup> Энэ гэмт хэргийн объектив тал нь зөвшөөрөлгүйгээр ой мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан идэвхтэй үйлдэл байна. Зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэсэн гэж сум дундын болон сум, дүүргийн ойн анги (байхгүй бол сум, дүүргийн эрх бүхий албан тушаалтан)-аас мод бэлтгэх эрхийн бичиг авалгүйгээр, эсхүл эрхийн бичигт заасан хэмжээнээс хэтрүүлж, эрхийн бичигт зааснаас өөр төрлийн мод, өөр ойгоос мод бэлтгэснийг ойлгоно. Гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан гэж иргэн, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллага нь ойгоос бэлтгэсэн мод, гуалин, шургааг, дүнз, зүсмэл материал, түлээг өөр аймаг, хот, суурины хооронд тээвэрлэх, худалдаалахдаа эрх бүхий албан тушаалтнаас гарал үүслийн гэрчилгээ авалгүйгээр тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсныг ойлгоно.

<sup>10</sup> Мөн тэнд

Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн үндсэн шинж нь байгаль орчинд хохирол учирсан байхыг шаардахгүй, хууль бусаар мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авснаар төгсдөг хэлбэрийн шинжтэй гэмт хэрэг юм.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 3 дах хэсэгт заасныг буюу хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэж зөвшөөрөлгүйгээр ой мод бэлтгэх, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэх, тээвэрлэх, худалдах, худалдан авах үйлдэл хийх нь тухайн хуулийн этгээдэд эдийн болон эдийн бус ашигтай байдал бий болох, мод бэлтгэх эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ авах төлбөр, хураамжийн зардлыг хэмнэх зэрэг ашиг сонирхлын төлөө үйлдсэнийг ойлгоно. Хууль бусаар мод бэлтгэх шийдвэрийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргасан байж болох бөгөөд энэ тохиолдолд хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.






## ХОЁР. ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ТООН МЭДЭЭНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Эрүүгийн хуулийн 24.1-24.9 дүгээр зүйлд заасан Хүрээлэн буй орчны эсрэг 9 гэмт хэрэг байна. 2018 - 2022 онд нийт 1355 хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг шүүхээр хянан шийдвэрлэгдсэний 232 нь 24.6 дугаар зүйл буюу Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг байжээ.<sup>11</sup> Үүний дараагаар Хууль бусаар ашигт малтмал ашиглах, олборлох гэмт хэрэг (24.2 дугаар зүйл) 97, Хууль бусаар ан агнах гэмт хэрэг (24.5 дугаар зүйл) 57, Байгалын ургамлыг хууль бусаар бэлтгэх гэмт хэрэг (24.8 дугаар зүйл) 20, Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг (24.3 дугаар зүйл) 9 байна. Хамгийн цөөн буюу Байгаль орчныг бохирдуулах гэмт хэрэг (24.1 дүгээр зүйл) 1, Ой, хээрийн түймэр тавих гэмт хэрэг (24.7 дугаар зүйл) 6 удаа үйлдэгдсэн бол Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэрэг (24.4 дүгээр зүйл), Байгалийн тэнцэл алдагдуулах гэмт хэрэг (24.9 дүгээр зүйл) 2022 онд Монгол Улсад үйлдэгдээгүй байна.

2018-2022 оныг хүртэл 5 жилийн хугацаанд 1355 хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн ба гэмт хэргийн тоо жил бүр өссөөр иржээ.<sup>12</sup>

График 1. 2018-2022 онд шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн тооны өсөлт



2018 оноос өмнөх тоон мэдээг ЦЕГ-ын тоон мэдээнээс авч үзэхэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 2013 онд 337, 2014 онд 287, 2015 онд 228, 2016 онд 165, 2017 онд 330 хэрэг, 2018 оны эхний 4 сард 113 хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 51-ээр буюу 45,1 хувиар өссөн буюу жил бүр нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<sup>13</sup>

2018-2022 оны 4 жилийн хугацаанд 1372 хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэнээс Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг 272, Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг 45, Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 811 байгаа нь 1128 буюу нийт хэргийн 82 хувийг эзэлж байна.<sup>14</sup>

2018-2022 онуудад дээрх 3 төрлийн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг тогтмол өссөн байх ба сүүлийн жилд буюу зөвхөн 2022 онд гэхэд 2021 онд үйлдсэн Хууль бусаар ашигт малтмал

<sup>11</sup> ШЕЗ-ийн Шүүн таслах ажиллагааны мэдээ, 2022 он


<sup>12</sup> ШЕЗ-ийн Шүүн таслах ажиллагааны мэдээ, 2018-2022 он

<sup>13</sup> ЦЕГ-ын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2019, 2020 он

<sup>14</sup> Мөн тэнд.

хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн хэргийн тоон мэдээ бараг 2 дахин нэмэгдсэн байна. Гэмт хэргийн төрөл бүрээр 5 жилийн хугацаанд нэмэгдсэн статистик нь дараах байдалтай байна.

График 2. Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийн өсөлт, бууралт (2018-2022 он)



Дээрх 1128 хэргийн шийдвэрээс 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлийн 3 дах хэсэгт зааснаар буюу хуулийн этгээдийг шүүгдэгчээр татсан шийдвэр 14 хэрэг байна. Хүрээлэн буй орчны гэмт хэргийг олон улсад хуулийн этгээд үйлдэх нь түгээмэл бөгөөд хуулийн этгээдийн зүгээс учруулж буй энэ төрлийн гэмт хэргийн хохирол хэдэн зуун тэрбум доллароор үнэлэгдэж буйг дээр өгүүлсэн. Тухайлбал, Монгол Улсад 2022 онд 7 хуулийн этгээд шүүхээр гэм буруутай нь тогтоогдож, эрүүгийн хариуцлага хүлээсэн байна. Эдгээр шийдвэр нь Эрүүгийн хуулийн 24.1.3 дугаар зүйлээр 1, 24.2.3-т холбогдох 1, 24.3 дугаар зүйлийн 3-д заасан 5 хэрэг байгаа юм.

Бидний судалгааны цар хүрээнд хамаарах 3 төрлийн гэмт хэргийг хуулийн этгээд үйлдсэнийг Хүснэгт 1-д харуулав. 2018-2023 онд Эрүүгийн хуулийн 24.2.3 дугаар зүйлд заасан “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” 5 гэмт хэрэг, Эрүүгийн хуулийн 24.3.3 дугаар зүйлд заасан “Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах” 8 гэмт хэрэг, “Хууль бусаар мод бэлтгэх” 1 хэргийг шүүхээр хянан шийдвэрлэжээ. Монгол Улсын албан ёсны шүүхийн шийдвэрийн сан болох [www.shuukh.mn](http://www.shuukh.mn) сайтад бүртгэгдсэн дээрх хэргүүдийг шийдвэрлэсэн шүүхүүд, огноог дэлгэрүүлж авч үзвэл:

Хүснэгт 1. Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлийн 3 дах хэсэгт заасан гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрүүд

№	Гэмт хэргийн төрөл	Шийдвэрлэсэн шүүх	Огноо	Тайлбар
1	24.2.3	Баянхонгор аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018.08.10	Цагаатгасан
2	24.2.3	Өмнөговь аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2018.12.10	Цагаатгасан
3	24.2.3	Баянхонгор аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2019.03.25	Ял шийтгэсэн
4	24.2.3	Баянхонгор аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2020.05.13	Ял шийтгэсэн
5	24.2.3	Төв аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2022.06.06	Ял шийтгэсэн
6	24.3.3	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дах сум дундын шүүх	2019.06.27	Ял шийтгэсэн
7	24.3.3	Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дах сум дундын шүүх	2019.11.20	Ял шийтгэсэн



8	24.3.3	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2022.01.10	Ял шийтгэсэн
9	24.3.3	Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2022.02.18	Ял шийтгэсэн
10	24.3.3	Дорноговь аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2022.06.08	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн
11	24.3.3	Дорноговь аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2022.06.20	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн
12	24.3.3	Дорноговь аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2022.06.30	Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн
13	24.3.3	Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2023.01.26	Ял шийтгэсэн
14	24.6.3	Төв аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх	2021.08.11	Ял шийтгэсэн

## 2.1. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧРУУЛСАН ХОХИРОЛ, ХОР УРШГИЙГ ШИЙДВЭРЛЭСЭН БАЙДАЛ

2018-2021 онд үйлдэгдсэн хүрээлэн буй орчны эсрэг 9 төрлийн гэмт хэргийн улмаас нийт учирсан хохирол 14 тэрбум бол үүнээс хувь хүн 3.1 тэрбум, хуулийн этгээд 10.9 тэрбум төгрөгийн хохирол учруулсан байна. Нөхөн төлөлтийн байдлыг авч үзэхэд нийт нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 4.3 тэрбум байгаагаас хувь хүн 875.1 сая, хуулийн этгээд 3.4 тэрбумыг нөхөн төлжээ.<sup>15</sup>

Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын хэмжээ 2018 онд 242.453.857, 2019

<sup>15</sup> ШЕЗ-ийн Шүүн таслах ажиллагааны тайлан 2018-2021 он.

онд 477.881.791, 2020 онд 181.036.259, 2021 онд 5.825.192.556, 2022 онд 1.267.337.400 гэсэн өсөлт бууралттай байсан байна. 2021 онд 5 тэрбум төгрөгт хүрч хамгийн өндөр хохирлыг учруулсан тоон мэдээтэй байна.

Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын хэмжээ дараах байдалтай байна. 2018 онд 122.605.063, 2019 онд 279.155.919, 2020 онд 400.677.058, 2021 онд 788.868.909, 2022 онд 1.156.955.146 болж тасралтгүй өсөхдөө сүүлийн нэг жилд бараг нэг дахин өссөн. Үүнийг График 3-т харуулав.

График 3. Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг үйлдсэний улмаас учруулсан хохирлын хэмжээ (2018-2022)



Гэмт хэргийн улмаас учруулсан дээрх хохирлыг нөхөн төлүүлсэн байдлыг харьцуулж үзвэл, 2022 онд 1.267.337.400 төгрөгийн хохирлыг Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн улмаас учруулсны 976.451.247 буюу 77 хувийг нөхөн төлүүлсэн бол 24.6 дугаар зүйлд заасан хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн улмаас учруулсан 1.156.955.146 төгрөгийн хохирлын 1.126.409.865 төгрөг буюу 97 хувийг төлүүлсэн буюу хамгийн өндөр нөхөн төлөлттэй байна. Энэ нь шүүхээр шийдвэрлэж буй гэмт хэргийн улмаас учруулсан



хохирлыг нөхөн төлүүлэх явдал өсөх хандлагатай байгааг харуулж байна. Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд заасан гэмт хэргийн улмаас учруулсан хохирол бусад 2 гэмт хэрэгтэй харьцуулахад маш бага байна. Тухайлбал, 2018, 2019 онд учруулсан хохирол байхгүй бол 2020 онд 5.500.000 төгрөгийн хохирол учруулсан гэсэн статистик гарсан байна.

## ГУРАВ. ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Энэхүү судалгааны хүрээнд хүрээлэн буй орчны эсрэг зарим төрлийн буюу Эрүүгийн хуулийн Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг (24.2 дугаар зүйл), Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэрэг (24.3 дугаар зүйл), 24.6 дугаар зүйл буюу Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийн 3 дах хэсэгт заасан (гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн) хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ.

2017 оны шинэчилсэн Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилж, тусгай ангийн 31 төрлийн гэмт хэрэгт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж байгаагийн гурав нь 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлд заасан хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг юм. Энэ төрлийн 14 гэмт хэрэг 2018-2022 онд шүүхээр шийдвэрлэгдсэн байна.

Анхан шатны шүүхээс хуулийн этгээдэд холбогдуулан шийдвэрлэсэн 14 шийдвэрээс 24.2.3 дугаар зүйлд заасан “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийг шийдвэрлэсэн 3, 24.3.3 дугаар зүйлд заасан “Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах” хэргийн 3 шийдвэр, 24.6 дугаар зүйлд заасан “Хууль бусаар мод бэлтгэх” хэргийн 1 шүүхийн шийдвэрийг сонгож, 7 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийлээ. Шүүхийн шийдвэрийг түүвэрлэн авахдаа хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн, ял шийтгэсэн, хэрэгсэхгүй болгож цагаатгасан зэрэг шийдвэрийн үр дүн, шийдвэрлэсэн шүүхүүдийг харгалзан үзэж сонгосон болно.



Хүрээлэн буй орчны эсрэг Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг, Химийн хорт аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах, Хууль бусаар мод бэлтгэх 3 төрлийн гэмт хэргийг шүүх хянан шийдвэрлэхдээ хуулийн этгээдийн төрлийг хэрхэн тодорхойлж байгаа, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдийг хэнээр тогтоож байгаа, хуулийн этгээд болон гэмт хэрэг гүйцэтгэсэн хувь хүнд давхар хариуцлага хүлээлгэж байгаа эсэх, ямар төрлийн ял, албадлагын арга хэмжээг оногдуулж байгаа зэрэгт дүн шинжилгээ хийх зорилгыг дэвшүүлсэн. Түүнчлэн энэ төрлийн гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын хэмжээ, хохирол нөхөн төлүүлж байгаа жишиг хандлагыг тодорхойлно.

### 3.1. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 24.2 ДУГААР ЗҮЙЛ “ХУУЛЬ БУСААР АШИГТ МАЛТМАЛ ХАЙХ, АШИГЛАХ, ОЛБОРЛОХ” ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

#### **Тохиолдол 1:**

##### *Шүүхийн шийдвэрийн товч утга*

Баянхонгор аймгийн Заг сумын 2-р багийн нутагт “Х Ө” ХХК нь тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал олборлох үйл ажиллагаа явуулсан байна. Тус ХХК нь нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулах гэрээтэйгээр Заг суманд ирсэн. Гэсэн хэдий боловч “тус суманд худаг гаргаж өгье, мөн хөрөнгө оруулалт хийе” шинэ газар өгөөч гэсэн хүсэлтийг сумын удирдлагад гаргасан. Сумын захиргаа хүсэлтийг хүлээн авсан хэдий ч бичгээр гэрээ байгуулаагүй байсан.

Нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахаар гэрээ байгуулсан хуулийн этгээд тухайн нөхөн сэргээлт хийх зардлаа тухайн газарт үүссэн байгаа хаягдал овоолго, ухагдсан нүхнээс гарсан шороо зэргийг угааж болохоор гэрээ хийсэн гэж мэдүүлсэн байна. Гэтэл тус газар нь цэвдэгтэй, техникийн нөхцөл хүнд байсан тул өөр газар заалган авч тэр газарт олборлолт хийж, зардлаа нөхөх зорилготой

байсан гэж хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдүүд мэдүүлсэн нь нөхөн сэргээлтийн гэрээгээр ашигт малтмал олборлох, ашиг олох зорилготой байсныг харуулж байна.

Сумын нутгийн удирдлагаас худаг гаргуулах, спортын заал бариулахад хандив авах, санхүүгийн тусламж авахаар өөрийн чиг үүрэг, эрх хэмжээнд хамаарахгүй зөвшөөрлийг олгож, ашигт малтмал хууль бусаар олборлоход дэмжлэг үзүүлж аман гэрээг хийсэн нь нотлогдсон байна.

Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээг өөрчлөх, гэрээнд өөрчлөлт оруулах, гэрээг сунгах, цуцлах зэрэг аливаа асуудлыг талууд бичгээр нөгөө талдаа мэдэгдэж тусгахаар зохицуулсан атал гэрээний талууд болох Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, 3 сумын засаг дарга, “Х Ө” ХХК-ын захирал Г.Х нараас бусад этгээдүүд болох 3 сумын нутгийн удирдлагууд “Х Ө” ХХК-ийн зөвлөх Д, уурхайн дарга О нар хоорондоо тохиролцож гэрээ хийх гэж байжээ. Энэ нь гэрч О манай компаниас 100.000.000 төгрөг Сумын удирдлагуудтай тохиролцож, гэрээнд зааснаас өөр газар ухахаар ярьж тохирсон, амралтын өдөр таарсан тул гэрээ байгуулж амжаагүй гэж мэдүүлснээс харагдаж байна.

Гэтэл тус аймгийн нутагт эвдэгдсэн газарт нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээдэд Аймгийн Засаг дарга гэрээ байгуулж эрх олгодог ба гэрээний дагуу зөвхөн эрх олгосон газарт нөхөн сэргээлт хийх ёстой байна. Гэрээнд заасан газрыг мэргэжлийн байгууллага хэмжиж өгдөг, сумын удирдлагад гэрээнд заасан газрыг өөрчлөх эрх хэмжээ байхгүй гэж гэрч Б мэдүүлсэн. Түүнчлэн гэрч Л “Х Ө” ХХК-ийн үйл ажиллагаа явуулах гэж байгаа газарт газрын даамал, багийн засаг дарга бид 3 очиж, цэг солбилцлыг бичиж тэмдэглэсэн. Тэр газар нь намгархаг газар байсан ба ямар нэг ухагдсан нүх шруп байгаагүй, нүхгүй газар юм чинь нөхөн сэргээлт хийх шаардлагагүй байсан” гэж мэдүүлсэн.





Дээрхээс дүгнэхэд “Х Ө” ХКК нь нөхөн сэргээлтгүйн үйл ажиллагаа явуулах гэрээгээр очсон газарт олборлолтын үйл ажиллагаа явуулдаг байсан төдийгүй гэрээнд заагаагүй, нөхөн сэргээлт хийх шаардлагагүй эрүүл газарт олборлолт хийсэн нь Эрүүгийн хуулийн 24.2.3 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийг хангажээ. Гэтэл шүүхээс “Х Ө” ХКК-ны уурхайн дарга О, зөвлөх албан тушаалтай Д нарыг хуулийн этгээдийг төлөөлөх бүрэн эрх бүхий этгээд биш төдийгүй нөхөн сэргээлт хийх гэрээнд тусгасан цэг солбилцолтой талбайгаас илүү гаргаж ухах аман тохиролцоог О, Д нар нь З сумын холбогдох удирдлагуудтай харилцан тохиролцсон болох нь нотлох баримтуудаар тогтоогдсон гэж дүгнэжээ.

Түүнчлэн шүүхээс “Баянхонгор аймгийн Прокурорын газраас дээр дурдсан асуудалд учир дутагдалтай дүгнэлт хийж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.2-т заасан этгээдийг зөв тогтоолгүй “Х Ө” ХКК, уг компанийн захирал Г.Х нарт холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2.3-д заасан “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг”-т зааснаар яллах дүгнэлт бичсэн нь буруу болжээ” гэжээ.

Иймд хэрэгт авагдсан баримтаар “Х Ө” ХКК, захирал Г.Х-д ашигтай шийдвэрлэгдэх “үндэслэл бүхий эргэлзээтэй байдлууд”-ыг нотлох баримтууд хэрэгт хангалттай цугларсан тогтоогдож байх тул шүүгдэгч нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж шийдвэрлэх нь үндэслэлтэй гэж шүүх шийдвэрлэсэн. Шүүх шүүгдэгч “Х Ө” ХКК, тус компанийн захирал Г.Х-ийг гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй гэж цагаатгасан ба энэхүү эрүүгийн хэрэгт Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжтэй үйл баримт тогтоогдсон тул хэргийг прокурорт буцааж, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг зөв тогтоох нь зүйтэй гэж үзжээ.

*Эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг шүүхээс тогтоож буй онцлог, давхар хариуцлага хүлээлгэсэн эсэх*

Шүүхийн шийдвэрт “Х Ө” ХКК-ны 2017 оны 04 дүгээр сарын 1-ний өдрийн 01/17 дугаартай “Ажилд томилох тухай” захирлын тушаалаар уурхайн даргаар Г.О-г томилж, компанийн үйл ажиллагааг хуулийн хүрээнд, ёс зүйтэй, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг үндэс болгон удирдан чиглүүлж, ажилчдын ажил үүргийн биелэлтэд шууд хяналт тавин ажиллахыг даалгасан тухай дурдсан боловч уурхайн дарга О нь тус ХКК-г бүрэн төлөөлөх эрх бүхий этгээд биш гэж дүгнэсэн. Гэтэл Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д заасан “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.” гэсэн заалт нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг заасан ба үүнд **нэгдүгээрт**, Эрүүгийн хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан гэмт хэргийг үйлдсэн байх, **хоёрдугаарт**, хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа эсхүл хамтран шийдвэр гаргасан, үйлдсэн байх, **гуравдугаарт**, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө байх гэсэн 3 үндсэн шинж юм.

Прокурорын зүгээс “Х Ө” ХКК-ны уурхайн дарга О, ХКК-ийн зөвлөх Д нарыг тус ХКК-ийг төлөөлөх эрх бүхий этгээд гэж үзэн Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 3-д заасан гэмт хэргийг хуулийн этгээдийг төлөөлөн үйлдсэн нь Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д зааснаар хуулийн этгээд эрүүгийн хариуцлага хүлээх үндэслэл болжээ гэж дүгнэн яллах дүгнэлт үйлдсэн нь үндэслэлтэй бөгөөд хууль ёсны дүгнэлт гэж үзэж байна. Учир нь Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд нь дан ганц хуулийн этгээдийн захирал бус Компанийн тухай хуульд зааснаар “84.1. Компанийн



төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.” гэсний дагуу уурхайн дарга О төлөөлөх эрх бүхий этгээдээр тооцогдох боломжтой юм.

Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 2-т заасан “Хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтанд хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, зөвшөөрөл өгч энэ хуульд заасан гэмт хэргийг бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй үйлдэл, эс үйлдэхүйгээр энэ хуульд заасан гэмт хэргийг үйлдсэн бол энэ хуульд заасан ял оногдуулна.” гэсэн заалтын дагуу тус ХХК-ийн захирал Г.Х-г яллагдагчаар татсан нь хууль зүйн үндэслэлтэй байсныг мөн дурдмаар байна.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрцүгийн харшлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дах хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсний дагуу “Х Ө” ХХК-ийг төлөөлөн шийдвэр гаргасан О, Д нарыг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй юм.

*Оногдуулж буй ялын хэмжээ, үр нөлөө, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршиг болон тэдгээрийг нөхөн төлүүлсэн байдал*

Шүүхийн шийдвэрээр хэргийг цагаатгасан тул ял болон хохирол нөхөн төлүүлэлтийн асуудалд дүн шинжилгээ хийх боломжгүй.

## Тохиолдол 2:

### *Шүүхийн шийдвэрийн товч утга*

2019 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Баянхонгор аймаг дах сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүх Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 3-т зааснаар шүүгдэгч “С Х” ХХК, шүүгдэгч Г.Э нарт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хянан хэлэлцжээ. “С Х” ХХК нь Баянхонгор аймгийн Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаатай нөхөн сэргээлт хийж, хамтран ажиллах гэрээ хийсэн бөгөөд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахдаа хууль бусаар ашигт малтмал олборлож байгаль экологид 13.019.318 төгрөгийн хохирол учруулсан. Тус хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд болох “С Х” ХХК-ны захирал албан тушаалтай шүүгдэгч Г.Э нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хангасан тул шүүгдэгч Г.Э-г гэмт хэргийн гүйцэтгэгчээр тооцсон байна.

Шүүгдэгч Г.Э-г тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг үйлдсэнд ял шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.9 дүгээр зүйлийн 2-т зааснаар тус тусад нь ял эдлүүлэхээр шийдвэрлэжээ. Ингэхдээ “С Х” ХХК-д торгох ял оногдуулж, хэсэгчлэн төлөхөөр тогтоон, үйл ажиллагаа явуулах эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, нэмэгдэл ялыг торгох ял оногдуулсан үеэс хугацааг тоолохоор шийдвэрлэсэн ба шүүгдэгч Г.Э-д хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнсэж, үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ хүлээлгэжээ. Түүнчлэн Г.Э-д 5.394.000 төгрөгийн хохирол гаргуулж, Их Богдын байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаанд олгуулах, 161.53 грамм алт бүхий (үнэ 13.019.318) шар өнгийн металлыг улсын орлого болгон хураан авахаар шийдвэрлэсэн байна.



*Эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг шүүхээс тогтоож  
буй онцлог, давхар хариуцлага хүлээлгэсэн эсэх*

Тус шүүхийн шийдвэрт эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг тогтоохдоо нэгдүгээрт, шүүгдэгч Г.Э-г тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэрэг үйлдсэн гэж, хоёрдугаарт шүүгдэгч “С Х” ХХК-ийг тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэж үзсэн. Шүүгдэгч Г.Э нь тус компанийг төлөөлөх эрх бүхий этгээд тул Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д зааснаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шийдвэр гаргажээ гэж дүгнэх үндэслэлтэй байна. Шүүхийн энэхүү шийдвэр нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий шийдвэр болсон төдийгүй шүүгдэгч Г.Э-г “С Х” ХХК-ийн нэрийн өмнөөс, түүний ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргаж, үйлдсэн нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хангасан тул тус гэмт хэргийн гүйцэтгэгчид тооцов гэсэн байна. Ингэж тооцсоноор шүүгдэгч Г.Э-д Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 2-т заасны дагуу буюу энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь “энэ зүйлийн 1, 2 дах хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн заалтыг хэрэгжүүлсэн гэж үзэхээр байна.

Шүүхээс Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д заасан “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дах хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн заалтыг хэрэгжүүлсэн шийдвэр гаргасан нь сайшаалтай байна. “С Х” ХХК-д эрүүгийн хариуцлага хүлээлгэхийн зэрэгцээ компанийн захирлыг гэмт хэргийн гүйцэтгэгчээр тооцож давхар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн сайн жишиг бүхий

шүүхийн шийдвэр гаргажээ гэж дүгнэж байна. Шүүгдэгч Г.Э нь “Овоо шанд”-ын нүхэн дотор тэсэлгээ хийсэн, бид нарын гаргасан чулуунууд бол өмнө нь хийсэн тэсэлгээний улмаас сул байсан чулуунууд, гаргах шийдвэрийг би өөрөө гаргасан...” гэх мэдүүлэг нь хууль бусаар ашигт малтмал олборлох шийдвэрийг гэмт хэргийн гүйцэтгэгч болох Г.Э дангаар гаргаж, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, түүний ашиг сонирхлын төлөө энэхүү гэмт хэргийг үйлдсэн болохыг нотолж байна. Иймд энэхүү шүүхийн шийдвэрт гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээд, түүнийг төлөөлөн шийдвэр гаргасан албан тушаалтныг хамтад нь эрүүгийн хариуцлага оногдуулах эрүүгийн хуулийн бодлого хэрэгжсэн гэж үзэж байна.

*Оногдуулж буй ялын хэмжээ, үр нөлөө, гэмт хэргийн улмаас  
учруулсан хохирол, хор уршиг болон тэдгээрийг нөхөн  
төлүүлсэн байдал*

Шүүхийн шийдвэрт хуулийн этгээд болох “С Х” ХХК-д Эрүүгийн хуулийн 3.2 дугаар зүйлийн 2, 5.7 дугаар зүйлийн 1, 9.4 дүгээр зүйлийн 1-д заасныг журамлан мөн хуулийн 24.2 дугаар зүйлийн 3-д зааснаар тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах буюу газрын хэвлийн нөхөн сэргээлт, эвдэрсэн газрын болон биологийн нөхөн сэргээлт хийх эрхийг нэг жилийн хугацаагаар хасаж, 20.000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 20.000.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэж, шүүгдэгч Г.Э-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1-д заасныг журамлан, Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1-д зааснаар хорих ял оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнсэж, нэг жилийн хугацаанд зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ хүлээлгэсэн байна.

Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 3-д заахдаа “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.” гэсэн байдаг.



Иймд шүүхийн шийдвэрээр торгох ялын хамгийн бага хэмжээг оногдуулсан төдийгүй эрх хасах ялын хэмжээг мөн доод хэмжээгээр оногдуулсан байна. Түүнчлэн шүүгдэгч Г.Э-д оногдуулсан ялын байдлыг үзэхэд анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, хувийн байдал зэргийг харгалзан хорих ялыг оногдуулахгүйгээр нэг жилийн хугацаагаар тэнсэх болон үүрэг хүлээлгэх албадлагын арга хэмжээ оногдуулсан байна.

Хуулийн этгээдэд оногдуулсан торгох ялыг 1 жилийн дотор хэсэгчлэн төлүүлэх ялын уян хатан бодлого баримталсан ба гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг шүүгдэгч Г.Э-ээс гаргуулахаар шүүхээс шийдвэрлэсэн байна.

### **Тохиолдол 3:**

#### *Шүүхийн шийдвэрийн товч утга*

Хуулийн этгээд “Т З Х” нөхөрлөл, түүний гүйцэтгэх удирдлага болох шүүгдэгч Ц.М нь 2020 оны 8 дугаар сарын 19-ний өдөр Төв аймгийн Заамар сумын 4 дүгээр багийн нутаг “Баянгол” гэх орон нутгийн тусгай хэрэгцээний 956 м<sup>2</sup> /1га/ газарт тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын олборлолт явуулж, байгаль орчинд 4 913 316 төгрөгийн хохирол учруулсан.

Шүүгдэгч Ц. М нь “Би гэрээнд заагдсан солбицол дээр ухаж үзээд алт гарахгүй болохоор нь өөр газар ухсан. Тэгээд ухсан газраас алт гарахгүй болохоор хамаг техник хэрэгслээ зогсоож хүмүүсээ амраасан. Би 20-30 машин шороо татсан, яг хэдэн тонн татсанаа мэдэхгүй байна” гэж мэдүүлсэн ба “2018 онд нөхөрлөл байгуулж уул уурхайн чиглэлээр ажиллах санаатай “Тосон заамарын хишиг” нөхөрлөлийг анх байгуулж байсан. Би өөрөө байгуулсан учраас гүйцэтгэх удирдлага дээр нь байдаг. Нөхөрлөл байгуулахад тус сумын иргэд дандаа байх ёстой гэсэн шаардлага тавьж байсан учраас тухайн үед сумандаа харьяалал бүхий 8 иргэний бичиг баримтыг олж Улсын бүртгэлийн газарт бүртгүүлж байсан. Тэр үед иргэдээс бичиг баримтыг нь авахдаа нөхөрлөл байгуулна гэдэг талаар хэлсэн болохоос үйл ажиллагаа явуулна гэж хэлээгүй. 2018,

2019 онуудад үйл ажиллагаа явуулаагүй учраас манай нөхөрлөлийн гишүүд бараг ийм нөхөрлөлд байдаг гэдгээ ч мэдэхгүй байгаа.” гэжээ.

*Эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг шүүхээс тогтоож буй онцлог, давхар хариуцлага хүлээлгэсэн эсэх*

Шүүхээс эрүүгийн хариуцлага оногдуулах этгээдийг тогтоохдоо Ц. М нь “Т З Х” нөхөрлөлийн гүйцэтгэх удирдлага бөгөөд тус хуулийн этгээдийг төлөөлөн, түүний ашиг сонирхлын төлөө тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын олборлолт явуулах гэмт хэрэг үйлдсэн тул Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д зааснаар “Т З Х” хуулийн этгээдийг шүүгдэгч гэж үзжээ.

“Т З Х” нөхөрлөл нь 2018 онд уул уурхайн чиглэлээр ажиллахаар байгуулагдсан хуулийн этгээд бөгөөд нөхөрлөл байгуулахад сумын иргэд байх ёстой гэсэн шаардлагын дагуу тухайн үед сумандаа бүртгэлтэй 8 иргэний бичиг баримтыг гуйж аваад Улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн байна. Гэсэн хэдий ч эдгээр хүмүүс нь тус нөхөрлөлийг үйл ажиллагаа явуулж байгааг, тэр тусмаа гэмт хэрэг үйлдсэн зэргийг мэдэхгүй байсан гэдгийг нөхөрлөлийн гүйцэтгэх удирдлага болох Ц.М-ийн “Нөхөрлөл байгуулахад тус сумын иргэд дандаа байх ёстой гэсэн шаардлага тавьж байсан учраас тухайн үед сумандаа харьяалал бүхий 8 иргэний бичиг баримтыг олж Улсын бүртгэлийн газарт бүртгүүлж байсан. ... 2018, 2019 онуудад үйл ажиллагаа явуулаагүй учраас манай нөхөрлөлийн гишүүд бараг ийм нөхөрлөлд байдаг гэдгээ ч мэдэхгүй байгаа” болон гэрч С.Б-ийн мэдүүлсэн “Одоогоос 3 жилийн өмнө миний танил М иргэний үнэмлэхээ өгөөч гээд нөхөрлөл байгуулах талаараа хэлсэн. Тэгээд би элдэв зүйл бодолгүй өгсөн, удалгүй буцаагаад өгсөн. ... Миний хувьд М-д итгээд иргэний үнэмлэхээ өгч явуулсан болохоос ямар нэг нөхөрлөлд хувь эзэмшдэг, ашиг орлого олсон, мөнгө төгрөг авсан зүйл байхгүй” гэх мэдүүлгээс нотлогдоно.





Нөхөрлөлийн тухай хуулиар нөхөрлөл нь 1. Бүх гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 2. Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл, 3. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл гэсэн 3 хэлбэртэй бөгөөд тус шүүхийн шийдвэрт “Т З Х” нөхөрлөл нь аль төрлийн нөхөрлөл болох нь тодорхойгүй байна. Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн тухайд Нөхөрлөлийн тухай хуулийн 32.4 дүгээр зүйлд “Тэрэнд өөрөөр заагаагүй бол хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөлийн аль ч гишүүн нөхөрлөлийг төлөөлж болно.” гэсэн заалт байдаг ч тус нөхөрлөлийн бусад гишүүд нь хуулийн этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд нь хамтран шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгч бусдаар үйлдүүлсэн гэх үйлдэл нотлогдохгүй байна. Иймд нөхөрлөлийн бусад гишүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл бүрдээгүй гэж үзэж болохоор байна.

Шүүхийн шийдвэрт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д зааснаар хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан хувь хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөхгүй гэсэн заалтын дагуу Ц.М-ийг шүүгдэгчээр тогтоосон нь давхар хариуцлагын зарчим бүхий Эрүүгийн хуулийн заалтыг зөв ашигласан нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх зарчмыг хангасан байна.

Шүүхийн шийдвэрийн шүүгдэгчийн биеийн байцаалт хэсэгт зөвхөн шүүгдэгч Ц.М-ийг тодорхойлж бичсэн нь учир дутагдалтай болсон ба уг хэсэгт шүүгдэгч хуулийн этгээдийн биеийн байцаалтыг бичих нь зүйтэй юм.

*Оногдуулж буй ялын хэмжээ, үр нөлөө, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршиг болон тэдгээрийг нөхөн төлүүлсэн байдал*

Шүүх шүүгдэгчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ гэм буруутайд тооцсон нотлох баримтад үндэслэн түүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагын

хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдал зэргийг харгалзан эрүүгийн хариуцлага хүлээлгэжээ. Шүүгдэгч Ц.М нь анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн, хохирол төлбөрийг нөхөн төлсөн байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 1-д зааснаар 5 400 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 5 400 000 төгрөгөөр торгох ял оногдуулж, шүүгдэгч хуулийн этгээд “Т З Х” нөхөрлөлд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 3-д зааснаар ашигт малтмал явуулах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 20000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 20.000.000 төгрөгөөр торгох ял оногдуулсан байна.

Шүүхээс хуулийн этгээдэд оногдуулсан дээрх 20.000.000 төгрөгийн ялын хэмжээ нь Эрүүгийн хуулийн 24.2.3-д заасан торгох ялын доод хэмжээ (3 жилийн хугацаанд хэсэгчлэн төлөх нөхцөлтэйгөөр) бөгөөд 2 жилийн эрх хасах ялын тухайд дундаж хэмжээгээр эрх хасах ял оногдуулсан байна. Харин шүүгдэгч Ц.М-д оноосон ял нь мөн Эрүүгийн хуулийн 24.2.1-д заасан ялын доод хэмжээ байгаа төдийгүй тус ялыг хэсэгчлэн (6 сарын хугацаанд) төлөхөөр тогтоосон нь ялыг шүүгдэгчийн төлбөрийн чадамжид тохируулан оногдуулсан уян хатан бодлогыг баримталжээ.

Түүнчлэн шүүгдэгч нараас гэмт хэргийн улмаас байгаль орчинд учирсан экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээг шинжээчийн дүгнэлтэд дурдсан хэмжээгээр гаргуулах үндэслэлтэй гэж үзэн, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дах хэсгийн 1-д зааснаар газрын хэвлийд учруулсан 2 241 833 төгрөгийн хохирлыг хоёр дахин нэмэгдүүлж 4.483.666 төгрөг, мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 5-д зааснаар газарт учирсан 928 төгрөгийн хохирлыг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 2784 төгрөгөөр, мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн 4-д зааснаар усанд учирсан 2.670.555 төгрөгийг гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 8.011.665 төгрөгөөр тооцож нийт 12 498 115 төгрөгийг шүүгдэгчээс гаргуулж үүнээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад төлсөн 5.000.000 төгрөгийг хасаж 7.498.115 төгрөг, үүн дээр нөхөн сэргээлтийн зардал 2 499 484





төгрөг нийт 9.997.599 төгрөгийг төлүүлэхээр шийдвэрлэсэн. Гэмт хэргийн улмаас учруулсан дээрх хохирол, хор уршгийг шүүгдэгч бүрэн төлж барагдуулжээ.

Шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан Ц.М-н эзэмшлийн Sintorik маркийн .. УНМ улсын дугаартай тээврийн хэрэгслийн үнэ 12 312 000 төгрөг, Ш.Э-ийн эзэмшлийн Loking маркийн ..УБ улсын дугаартай чиргүүлийн үнэ 3.500.000 төгрөгийг буюу нийт 15.812.000 төгрөгийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 2 дах хэсэгт зааснаар шүүгдэгчээс гаргуулж улсын төсөвт оруулахаар шийдвэрлэсэн байна.

### 3.1. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 24.3 ДУГААР ЗҮЙЛИЙН “ХИМИЙН ХОРТ, АЮУЛТАЙ БОДИСЫГ ХУУЛЬ БУС ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ” ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйл буюу Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэргийг үйлдсэн хуулийн этгээдийн хэргийг шийдвэрлэсэн Дорноговь аймаг дах сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 6 дугаар сард шийдвэрлэсэн 3 хэргээс 2020 оны 6 дугаар 30-ны өдрийн шүүхийн шийтгэх тогтоолд дүн шинжилгээ хийхээр сонгов. Дээрх 3 хэрэг нь хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн хэргүүд ба 2 нь БНХАУ-ын 100 хувийн хөрөнгө оруулалттай хуулийн этгээд байв.

#### **Тохиолдол 4:**

##### *Шүүхийн шийдвэрийн товч утга*

Дорноговь аймгийн Иххэт сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт жонш баяжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Х” ХХК нь жонш баяжуулах үйлдвэрийн лабораторидоо 2019 оноос 2022 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны А/356/396 хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын

жагсаалтад орсон Этилийн спирт 99.7% 500 миллитрийн шилтэй бодис 47 ширхэг, Цууны хүчил 500 миллитрийн шилтэй бодис 65 ширхэг, Борын хүчил 500 миллитрийн шилтэй бодис 40 ширхэг, Идэмхий кали 500 миллитрийн шилтэй бодис 52 ширхэг, Натрийн сульфид 500 миллитрийн шилтэй бодис 20 ширхэг, Давсны хүчил 1 литрийн савлагаатай 12 ширхэг, Фторт устөрөгч 500 миллитрийн шилтэй бодис 8 ширхэг, Нүүрстөрөгчийн натри 500 миллитрийн шилтэй бодис 20 ширхэг, Цагаан тугалганы хлорид 500 граммын шилтэй бодис 2 ширхэг, Идэмхий натри 500 граммын шилтэй бодис 1 ширхэг, Этанол амин 500 миллитрийн шилтэй бодис 1 ширхэг, Кальцейн 5 литрийн савлагаатай 23 ширхэг гэх бодисуудыг, мөн Засгийн газрын 2007 оны Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалтад багтсан 3 этанол амин 500 миллитрийн шилтэй бодис 81 ширхэг зэрэг химийн хорт болон аюултай бодисыг тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, хадгалсан гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогджээ. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч “Х” ХХК-ийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3 дах хэсэгт заасан химийн хорт, аюултай бодисыг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хууль бусаар хадгалсан гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцжээ.

Энэ нь шүүгдэгч “Х” ХХК-ийн хууль ёсны төлөөлөгч R.D шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн “2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс тогтвортой үйл ажиллагааг явуулж байна. “Х” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар би 2017 оны 1 сараас ажиллаж байгаа. Манай үйлдвэр 2018 оны 12 дугаар сарын 09-ний өдөр улсын онцгой комисс хүлээж аваад үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулсан. Тухайн үед химийн бодисыг тусгасан болохоор зөвшөөрөл олгосон гэж буруу ойлгосон байна лээ. Зарим төрлийн химийн бодисоо Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас оруулж ирдэг мөн Монгол Улсад химийн бодис зардаг “Ц Трейд” ХХК-аас авдаг. Ямар төрлийн бодисоо Монгол Улсын хилээр оруулж ирдэг ямар бодисоо дотоодын компаниас худалдан авдаг болох талаар мэдэхгүй байна. Энэ нь бидний буруу, химийн



хорт бодис ашигласнаа хүлээн зөвшөөрнө” гэсэн мэдүүлэг, хэргийн газарт үзлэг хийсэн тухай тэмдэглэл, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн дүгнэлт, хохирогч, иргэний нэхэмжлэгч, гэрчүүдийн мэдүүлгүүдээр нотлогдсон байна.

Шүүхийн шийдвэрт “химийн хорт бодис” гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн элемент, тэдгээрийн нэгдлийг хэлэх бөгөөд химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар хадгалсан нь нийгмийн аюулгүй байдал болон хүн амын эрүүл мэндэд гэм буруугийн хэлбэрээр халдсан нийгэмд аюултай үйлдэл болохыг Эрүүгийн хуулиар тодорхойлсон гэдгийг дурдаад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлд “Энэ хуулийн тусгай ангид заасан, нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно” гэж, 9.1 дүгээр зүйлийн 1-д “Энэ хуулийн тусгай ангид заасан хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно” гэж заасны дагуу шүүгдэгч “Х” ХХК-ийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэж дүгнэсэн.

*Эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг шүүхээс тогтоож буй онцлог, давхар хариуцлага хүлээлгэсэн эсэх*

Шүүхээс эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг тодорхойлохдоо Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлд заасан “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах

*үндэслэл болно.”* гэсний дагуу “Х” ХХК-ийг Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд заасан “Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах гэмт хэрэг үйлдсэн гэжээ.

Дорноговь аймгийн Их хэт сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт жонш баяжуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Х” ХХК нь БНХАУ-ын 100 хувь хөрөнгө оруулалттай хуулийн этгээд бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд компанийн гүйцэтгэх захирал буюу хууль ёсны төлөөлөгч R. D оролцсон байна.

Шүүхийн шийдвэрт хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахаар шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д заасан “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дах хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нь шүүхийн шийдвэр хууль ёсны байх зарчмыг хангасангүй.

Шүүгдэгч “Х” ХХК-ийн хууль ёсны төлөөлөгч R.D шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн “2018 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс тогтвортой үйл ажиллагааг явуулж байна. Х ХХК-ийн гүйцэтгэх захирлаар би 2017 оны 1 сараас ажиллаж байгаа.” гэсэн мэдүүлгээс үзэхэд гүйцэтгэх захирал R.D нь тус хуулийн этгээдийг тогтвортой үйл ажиллагаа явуулж эхлэхээс өмнө шийдвэр гаргах бүхий эрх албан тушаалтнаар ажиллаж байсныг нотолж байна. Иймд Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д зааснаар R.D нь компанийн хууль ёсны төлөөлөгчөөр бус шүүгдэгчээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохын зэрэгцээ эрүүгийн хариуцлага хүлээх этгээд байсан байна. Иймд давхар хариуцлага оногдуулах эрх зүйн зохицуулалт хэрэгжээгүй төдийгүй гэмт хэргийн гүйцэтгэгчийг ял завшуулсан шийдвэр гарсан гэж дүгнэж байна.



*Оногдуулж буй ялын хэмжээ, үр нөлөө, гэмт хэргийн улмаас  
учруулсан хохирол, хор уршиг болон тэдгээрийг нөхөн  
төлүүлсэн байдал*

Шүүгдэгч “Х” ХХК болон өмгөөлөгчийн талаас гэм буруугийн талаар маргаагүй, хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлэхээр шүүхэд хүсэлт гаргасныг шүүх хүлээн авч урьдчилсан хэлэлцүүлгийн шүүх хуралдааныг явуулж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 17.4 дүгээр зүйлийн 4-д заасан нөхцөл байдал хангагдсан гэж үзээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3-д зааснаар шүүгдэгч “Х” ХХК-ын Хэнтий аймгийн Галшир сумын Баруун буянт нэртэй газрын 177,41 гектар талбай бүхий уурхайн талбайд ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг 1 (нэг) жилийн хугацаагаар хасаж, 30000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр буюу 30.000.000 төгрөгөөр торгох ял шийтгэжээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 4, 5-д зааснаар шүүгдэгч “Х” ХХК нь шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц торгох ялыг 8 сарын хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож, шүүхээс тогтоосон хугацаанд торгох ялыг биелүүлээгүй бол торгох ялын 15 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг 1 хоногоор тооцож хорих ялаар солихыг анхааруулжээ. Шүүхийн шийдвэрт хуулийн этгээдэд оногдуулсан торгох ялыг хорих ялаар солихоор шийдвэрлэсэн нь онцлог байна. Учир нь хуулийн этгээдэд хорих ял оногдуулах боломжгүй тул ялыг солих талаар шийдвэр биелэгдэх боломжгүй юм.

Түүнчлэн гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршгийг нөхөн төлүүлэх талаар шийдвэрлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.6 дугаар зүйлийн 1, 2-т зааснаар шүүгдэгч “Х” ХХК-аас шинжээчийн зардал 50,000 (тавин мянга) төгрөгийг гаргуулж Дорноговь аймаг дах Цагдаагийн газарт олгох талаар, мөн шүүгдэгч “Х” ХХК нь бусдад төлөх төлбөргүй, хуулийн этгээдийн бичиг баримт шүүхэд ирээгүй, битүүмжлэгдсэн хөрөнгөгүй болохыг дурджээ.

## **Тохиолдол 5:**

### *Шүүхийн шийдвэрийн товч утга*

Шүүгдэгч “Х” ХХК нь Сүхбаатар дүүргийн 12 дугаар хороо, Хангайн 00 тоотод үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тус компанийн захирал Б нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн шинжээчдийн багаар Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодис ашиглах дүгнэлт гаргуулж, ашиглах зөвшөөрөл авалгүйгээр Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/356/396 хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтын химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалтын 853 дугаарт Метанол (CH<sub>3</sub>OH), 408 дугаарт хүхрийн хүчил (H<sub>2</sub>SO<sub>4</sub>), 114 дугаарт азотын хүчил (HNO<sub>3</sub>) зэрэг химийн бодисыг “Р” ХХК болон бусад этгээдүүдээс их хэмжээгээр худалдан авч 2022 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэлх хугацаанд хууль бусаар үйл ажиллагаандаа ашиглаж, үлдэгдэл 64.1 кг бодисыг хадгалсан хэрэг үйлджээ.

Шүүгдэгч “Х” ХХК-ийн хууль ёсны төлөөлөгч Б “...Манай “Х” ХХК нь 2016 оноос хойш одон тэмдэг, медаль, ромбо хийхдээ металл өнгөлгөөнд нь хүхрийн хүчил, азотын хүчил зэрэг химийн бодисуудыг зөвшөөрөлтэй компани болох “Р” ХХК, “Ц” ХХК-уудаас худалдан авч ашигладаг байсан. Химийн бодисуудыг өнгөлгөөнд ашиглахад бага хэрэглэдэг тул удаан уусдаг. Хүхрийн хүчил, азотын хүчил зэргийг усаар шингэлж эсхүл шингэлснийхээ дараа хооронд нь хольж буюу дангаар нь саванд хийж тавиад хийсэн металл бүтээгдэхүүнүүдээ дүрж зайлж авах зэргээр өнгөлдөг. Энэ металл дээр байгаа тос, хаг, нагаар зэрэг бохирдлуудыг арилгаж металлын үндсэн өнгийг нь гаргадаг... Хамгийн сүүлд “Ц” ХХК, “Р” ХХК-уудаас 2017, 2019 онуудад азотын хүчил, хүхрийн хүчил зэргийг худалдан авч хэрэглэж байгаад үлдэгдэл нь сая шалгалтаар хураагдсан. Манай компани нь тусгай зөвшөөрөлгүйгээр химийн



бодис үйл ажиллагаандаа хэрэглэж, хадгалсан буруугаа хүлээн зөвшөөрч байна” гэж мэдүүлжээ.

Шүүгдэгч “Х” ХХК нь химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, хадгалсан болох нь хэргийн газрын үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлтүүд, гэрчүүдийн мэдүүлэг, эд мөрийн баримт хураан авсан тухай тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлт, Шинжлэх ухааны академи Хими, химийн технологийн хүрээлэнгийн шинжээчийн дүгнэлт, шинжээчийн мэдүүлэг болон шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч Б-ийн мэдүүлгээр нотлогдсон байна.

“Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан” гэдэгт тухайн хүн, хуулийн этгээд хуульд заасны дагуу зохих тусгай зөвшөөрлийг аваагүй тохиолдолд ямар ч байдлаар химийн хорт, аюултай бодистой харьцаж, өөрсдөдөө хамааруулан үйл ажиллагаа явуулж болохгүй бөгөөд ийнхүү үйл ажиллагаа явуулсан үйлдлийг ойлгоно.

*Эрцүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг шүцхээс тогтоож буй онцлог, давхар хариуцлага хүлээлгэсэн эсэх*

Шүүхийн шийдвэрт шүүгдэгчийн биеийн байцаалтыг тогтоохдоо “Х” хязгаарлагдмал хариуцлагатай компани, 2008 оны 8 дугаар сарын 11-ний өдөр Монгол Улсын хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн, 0 улсын бүртгэлийн дугаартай, 0 регистрийн дугаартай, бэлэг дурсгал, гоёл чимэглэлийн бүтээгдэхүүний худалдаа, барилгын материал худалдаа, газар тариалан эрхлэх, гадаад худалдаа, мал аж ахуй эрхлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхтэй (үйл ажиллагаа явуулдаг), урьд ял шийтгэлгүй” гэжээ.

Тус ХХК-ийн захирал албан тушаалтай Б нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө Химийн хорт болон аюултай бодисын бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн үндэсний зөвлөлийн шинжээчдийн багаар Монгол Улсад ашиглахыг

хязгаарласан химийн хорт болон аюултай бодис ашиглах дүгнэлт гаргуулж, ашиглах зөвшөөрөл авалгүйгээр химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалтад орсон Метанол ( $\text{CH}_3\text{OH}$ ), хүхрийн хүчил ( $\text{H}_2\text{SO}_4$ ), азотын хүчил ( $\text{HNO}_3$ ) зэрэг химийн бодисыг “Р” ХХК болон бусад этгээдүүдээс их хэмжээгээр худалдан авч, хууль бусаар үйл ажиллагаандаа ашиглаж, үлдэгдэл бодисыг хадгалсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3-д заасан гэмт хэрэг үйлдсэн нь Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д зааснаар “Х” ХХК-ийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл болжээ.

“Х” ХХК-ийн захирал Б нь тус компанийг төлөөлөх эрх бүхий этгээд мөн бөгөөд хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө өөрийн компанийн үйл ажиллагаандаа тусгай зөвшөөрөлгүйгээр химийн бодис үйл ажиллагаандаа хэрэглэж, хадгалсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна. Өөрөөр хэлбэл, хүхрийн хүчил, азотын хүчил зэргийг усаар шингэлж эсхүл шингэлснийхээ дараа хооронд нь хольж буюу дангаар нь саванд хийж тавиад хийсэн металл бүтээгдэхүүнүүдээ дүрж зайлж авах зэргээр өнгөлдөг. Энэ нь металл дээр байгаа тос, хаг, нагаар зэрэг бохирдлуудыг арилгаж металлын үндсэн өнгийг нь гаргадаг гэж мэдүүлсэн нь “Х” ХХК-д Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн 3-д зааснаар ял оногдуулахад нөлөөлсөн байна.

Харин Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д зааснаар “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2-т заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй нь мөн өмнөх шүүхийн шийдвэрийн нэгэн адилаар давхар хариуцлага оногдуулахгүй хувь хүнийг ял завшуулсан нөхцөл байдал тогтоогдож байна.





*Оногдуулж буй ялын хэмжээ, үр нөлөө, гэмт хэргийн улмаас  
учруулсан хохирол, хор уршиг болон тэдгээрийг нөхөн  
төлүүлсэн байдал*

Шүүхээс шүүгдэгч “Х” ХХК-д шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзсэний үндсэнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3-д зааснаар химийн хорт аюултай бодистой холбоотой үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж, 20000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг буюу 20.000.000 төгрөгөөр торгох ял оногдуулахаар шийдвэрлэжээ. Ингэхдээ шүүгдэгчийн ажил хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг харгалзан торгох ялыг 3 сарын хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоов.

Түүнчлэн гэмт хэргийн улмаас учирсан бодит хохирол тогтоогдоогүй тул “Х” ХХК-ийн хууль ёсны төлөөлөгчийг бусдад төлөх төлбөргүй болохыг дурдаад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.5 дугаар зүйлийн 6-д зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан Экологийн цагдаагийн албанд хадгалагдаж байгаа 17.7 литр Метанол ( $\text{CH}_3\text{OH}$ ), 31.3 литр хүхрийн хүчил ( $\text{H}_2\text{SO}_4$ ), 12.4 литр азотын хүчил ( $\text{HNO}_3$ ), хүхрийн хүчил ( $\text{H}_2\text{SO}_4$ )-ийн холимог, 1.3 литрийн зэсийн сульфат ( $\text{CuSO}_4$ ), азотын хүчил ( $\text{HNO}_3$ )-ийн холимог, 1.4 литрийн азотын хүчил ( $\text{HNO}_3$ ), зэсийн сульфат ( $\text{CuSO}_4$ ), хүхрийн хүчил ( $\text{H}_2\text{SO}_4$ )-ийн холимог зэргийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц устгуулахаар зохих байгууллагад шилжүүлэхийг Экологийн цагдаагийн албанд даалгасан байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 5-д зааснаар шүүгдэгч “Х” ХХК-ийн хууль ёсны төлөөлөгч Б нь шүүхээс оногдуулсан торгох ялыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй тохиолдолд шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож, хорих ялаар солихыг анхааруулсан шийдвэр гаргасан нь онцлогтой байна. Учир нь хуулийн этгээдэд оногдуулсан торгох ялыг хорих

ялаар солихоор шийдвэрлэсэн нь биелэгдэх боломжгүй байсан бол энэхүү шүүхийн шийдвэрт хуулийн этгээдэд оногдуулсан ялыг түүний хууль ёсны төлөөлөгч болох захиралд хорих ялаар сольж эдлүүлэхээр шийдвэрлэсэн нь ялыг халдаан хэрэглэсэн буюу Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлийн 3 дах хэсэгт заасан “Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй.” гэсэн заалтыг зөрчсөн шийдвэр болжээ гэж дүгнэлээ.

#### **Тохиолдол 6:**

##### *Шүүхийн шийдвэрийн товч утга*

Шүүгдэгч “С А” ХХК /РД0000000/ нь 2020 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт мяндас полимер арматурын үйлдвэрлэл явуулахдаа Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамааруулсан бодисын жагсаалтад багтсан 2, 4, 6-трис /диметиламинометал/ фенол, эпоксидийн давирхай зэрэг химийн хорт болон аюултай бодисыг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, ашиг сонирхлын төлөө хууль бусаар ашиглан үйл ажиллагаа явуулсан, хадгалсан гэмт хэрэг үйлдсэн нь хэргийн газарт үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зураг, дүрс бичлэг, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 2020 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 06/7239 дугаартай албан бичиг, “Реактив” ХХК-ийн 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 8 дугаартай албан бичиг, Шинжлэх ухааны академийн хими, химийн технологийн хүрээлэнгийн шинжээчийн дүгнэлт, гэрч нарын мэдүүлгээр нотлогдсон гэж шүүх дүгнэжээ.

*Эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг шүүхээс тогтоож  
буй онцлог, давхар хариуцлага хүлээлгэсэн эсэх*

Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх болсон үндэслэл нь Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж,





эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.” гэсний дагуу хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд болох компанийн захирал Д-ийн хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл гэж шүүхээс үзсэн байна.

Гэсэн хэдий ч шүүхийн шийдвэрт компанийн захирал Д-г гэмт хэргийн гүйцэтгэгчээр бус харин компанийн хууль ёсны төлөөлөгчөөр тогтоосон ба шүүхийн хэлэлцүүлэгт “С А” ХХК-ийн хууль ёсны төлөөлөгч Ц.Д мэдүүлэхдээ: “...Мөрдөн шалгах ажиллагаанд өгсөн мэдүүлэг үнэн зөв учир нэмж мэдүүлэг өгөхгүй.” гэснийг тусгажээ. Ц.Д нь ямар мэдүүлэг өгсөн нь шүүхийн шийдвэрт тусгагдаагүй бөгөөд гэрч Г.Э-ийн “... С А” ХХК-г 2020 оноос эхлэн мэдэх болсон. “С А” ХХК нь Ц.Д захирлын өөрийнх нь компани байгаа юм. Арматурын үйлдвэрийг 2020 оны эхнээс барих болсон Хонхорт байрладаг талаар нь мэднэ гэхдээ үйлдвэр дээр нь очиж байгаагүй. Би “С А” ХХК-ын үйл ажиллагааны талаар бол мэдэхгүй. 2020 оны 08 дугаар сард Д захирал намайг дуудаад би амжихгүй байна чи энэ гэрээг авч яваад энэ компанитай гэрээ байгуулаадах гэрээ байгуулсны дараа зээл авах гэж байгаа юм. Мөнгө босгох хэрэгтэй байна гээд миний нэрээр боловсруулсан гэрээг надад өгөхөөр нь 2020 оны 08 дугаар сарын 05-ны өдөр “Полиуретан Хөөс” ХХК-ын захирал гээд нэг залуутай очиж гэрээ байгуулсан. “С А” ХХК-д ямар хүмүүс ажилладаг талаар мэдэхгүй. Ерөнхийдөө шинэ компани учраас захирал ганцаараа толгойлоод удирдаад яваад байсан” гэж мэдүүлснээс харахад компанийн захирал Ц.Д нь ганцаар шийдвэр гарган, өөрийн компанийн менежер албан тушаалтай Г.Э-д үүрэг өгөн хуулийн этгээдийн нэрийн өмнөөс гэмт хэрэг үйлджээ.

Компанийн захирал Д-д Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй байсан боловч зөвхөн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж, хувь хүнийг ял завшуулж шийдвэрлэжээ.

*Оногдуулж буй ялын хэмжээ, цр нөлөө, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршиг болон тэдгээрийг нөхөн төлмүүлсэн байдал*

Шүүхээс “С А” ХХК-ийг “Химийн хорт, аюултай бодисыг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, ашиг сонирхлын төлөө хууль бусаар ашигласан, хадгалсан” гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.3 дугаар зүйлийн 3-д зааснаар “С А” ХХК-ийг 20.000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 20.000.000 төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ. Түүнчлэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 4-д зааснаар “С А” ХХК нь шүүхээс оногдуулсан торгох ялыг 3 жилийн хугацаанд хэсэгчлэн төлөхийг тогтоосон байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 5-д зааснаар “С А” ХХК нь торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солихыг дурдсан нь мөн биелэгдэх боломжгүй шийдвэр болжээ. Учир нь хуулийн этгээд нь хорих ял эдлэх боломжгүй субъект тул торгох ялыг солих боломжгүй юм. Эрүүгийн хуульд хуулийн этгээдэд нэг төрлийн буюу торгох ял л оногдуулахаар хуульчилсан нь учир дутагдалтай болох нь энэхүү шийдвэрээс харагдаж байна. Хуулийн этгээд торгох ялыг биелүүлэхгүй тохиолдолд татан буулгах, эд хөрөнгө хураах зэргээр солих ялын алтернатив хувилбар хэрэгтэй байна.



### 3.3. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 24.6 ДУГААР ЗҮЙЛ “ХУУЛЬ БУСААР МОД БЭЛТГЭХ” ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ШИНЖИЛГЭЭ

#### Тохиолдол 7:

##### *Шүүхийн шийдвэрийн товч утга*

Шүүх шүүгдэгч А.Д-г Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 9.1 дүгээр зүйлийн 3-ыг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлийн 3-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзжээ. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч А.Д нь 2020 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Төв аймгийн Борнуур сумын Нарт 4-р багийн нутаг “Шивэртэй” гэх газраас зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ой мод бэлтгэж, энэ хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдэж байгаль орчинд хохирол учруулсан.

Энэ нь хэргийн газарт үзлэг хийсэн тэмдэглэл, нөхөн үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлт, мод хураан авсан тэмдэглэл, “Ш О” ХХК-ийн бичиг баримтууд, эд хөрөнгө битүүмжилсэн тухай тэмдэглэл, Гэрч Х.Ерханатын өгсөн “...Би 2020 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Анхаа, Билгүүнээ нарын хамт 20-96 УБК улсын дугаартай цагаан өнгийн мазда маркийн машинтай Улаанбаатар хотоос Төв аймгийн Борнуур сумын нутагт очиж ... модтой уулнаас 60 ширхэг нарс модны суулгацыг хүрдэж аваад ногоон өнгийн шуудайнуудаар үндсийг нь боосон. Тэгээд модоо хийж дуусаад доошоо Урьхан зоогийн газар руу буцаж очиж модны суулгац ачих машинаа авчирч даваан дээр гаргаж орхиод давааны цаад талаас Мазда маркийн машинаар бэлтгэсэн суулгацуудаа зөөж том ачааны машиндаа ачиж дуусаад доошоо уруудаад явж байгаад цагдаа нартай таарсан. Миний ажилладаг Шинэс ой ХХК-ийн захирал Д гэдэг хүн 5 дугаар сарын 23, 24-ний хавьцаа намайг дагуулж бидний мод бэлтгэсэн газар аваачиж эндээс мод бэлтгээрэй гэж хэлсэн. Тэгээд би тэр газарт нь очиж мод бэлтгэсэн. Миний ажилладаг компанийн захирал зөвшөөрөлтэй ямар ч асуудал байхгүй гэж хэлсэн. Би мод бэлтгэсэн газраа зааж чадна. Миний ажилладаг

компани бол Төв аймгийн Батсүмбэр сумын нутаг дэвсгэрт мод үржүүлэг болон ногоо тарих үйл ажиллагаа явуулдаг компани байгаа юм” гэх зэрэг гэрчүүдийн мэдүүлэг, шүүгдэгч А.Д-ийн “Би 2019 оны 5 дугаар сард Нью тур гэж аялал жуулчлалын компанитай гэрээ байгуулж, тус компанийн талбайд 2,5-3 метр урттай 250 ширхэг нарс мод тарихаар болсон бөгөөд тухайн үед мод бэлтгэх зөвшөөрөл олдоогүй. Тухайн үед Батсоёмбо гэдэг хувь хүнээс 250 ширхэг нарс мод худалдан авахаар тохиролцож түүнд 10 гаруй сая төгрөг шилжүүлж түүнээс 250 ширхэг нарс мод худалдан авч Нью тур гээд компанийн талбай дээр тарьсан. Тэгтэл нөгөө тарьсан моднуудыг 100 орчим мод нь үхсэн байсан ... Би энэ компанийг анх 2007 онд үүсгэн байгуулсан бөгөөд мод үржүүлэг, хүнсний ногоо тарих чиглэлээр одоо Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол гэдэг газар үйл ажиллагаа явуулж байна. Манай байгууллага зөвшөөрөл аваагүй... Би модны суулгац бэлтгэх эрх авахаар олон байгууллагад хандсан боловч эрх олдоогүй, мөн Нью тур компанид өрөнд орсон учир аргагүй байдалд орсны улмаас энэ үйлдлийг хийсэн” гэх мэдүүлэг зэргээр нотлогджээ.

*Эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг шүүхээс тогтоож буй онцлог, давхар хариуцлага хүлээлгэсэн эсэх*

Шүүхээс шүүгдэгчээр А.Д-г тогтоож Эрүүгийн хуулийн 24.6 дугаар 3-ыг журамлан зөвшөөрөлгүйгээр хууль бусаар мод бэлтгэж энэ хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэж үзэн хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн. Шүүхийн шийтгэх тогтоолд шүүгдэгчийн биеийн байцаалт хэсгийг бичээгүй нь учир дутагдалтай юм. Учир нь шүүгдэгч А.Д-г Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д зааснаар гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс үйлдсэн гүйцэтгэгчээр тооцож “Ш О” ХХК-ийг шүүгдэгчээр давхар тогтоох нь зүйтэй юм.

Шүүхийн шийдвэрийн агуулга болон хэлбэрт гаргасан алдаа нь хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, түүнийг төлөөлөх эрх бүхий этгээдийн хийсэн үйлдэл нь хуулийн этгээдийг шүүгдэгчээр



тогтоож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл гэдгийг тогтоогоогүй явдал юм.

Шүүгдэгч А.Д-ийн “2020 оны 5 дугаар сарын 28-ний өдөр гэрч гэх залуу манайд ажиллаж байсан. Компанид мод хэрэгтэй байсан нь үнэн... Би энэ компанийг анх 2007 онд үүсгэн байгуулсан бөгөөд мод үржүүлэг, хүнсний ногоо тарих чиглэлээр одоо Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол гэдэг газар үйл ажиллагаа явуулж байна. Манай байгууллага зөвшөөрөл аваагүй. Би дээрх моднуудыг Нью тур гэдэг компанийн талбайд тарих гэж байсан юм. Би модны суулгац бэлтгэх эрх авахаар олон байгууллагад хандсан боловч эрх олдоогүй, мөн Нью тур компанид өрөнд орсон учир аргагүй байдалд орсны улмаас энэ үйлдлийг хийсэн” гэх мэдүүлэг нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл болохыг нотолж байна. Түүнчлэн А.Д нь “Ш О” ХХК-ийн захирал бөгөөд хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг бусдаар үйлдүүлэхдээ хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргажээ. Энэ нь Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д заасан “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд ял оногдуулахаар заасан гэмт хэргийн шинжийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан дангаараа, эсхүл хамтран шийдвэр гаргаж, эсхүл хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө хийсэн үйлдэл, эс үйлдэхүйгээр хангасан нь хуулийн этгээдэд ял оногдуулах үндэслэл болно.” гэсэн заалтыг хангаж байна. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаагаар “Ш О” ХХК нь 2007 оны 3 дугаар 29-ний өдөр А.Д-ийн нэг хүний гишүүнчлэлтэй үүсгэн байгуулагдаж, иод үржүүлгийн үйл ажиллагаа явуулдаг болох нь тогтоогдсон.

Шүүгдэгч А.Д-д эрүүгийн хариуцлага хүлээлгэхээс гадна Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-д зааснаар “Ш О” ХХК-г шүүгдэгчээр татаж эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй нь хуулийн этгээдийг ял завшуулах нөхцөл байдлыг бий болгосон.

*Оногдуулж буй ялын хэмжээ, цр нөлөө, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршиг болон тэдгээрийг нөхөн төлүүлсэн байдал*

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 9.1 дүгээр зүйлийн 3-д заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.6 дугаар зүйлийн 3-д зааснаар “Ш О” ХХК, шүүгдэгч А.Д-г 20 000 (хорин мянга) нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 20 000 000 (хорин сая) төгрөгөөр торгох ялаар шийтгэжээ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 4-д зааснаар оногдуулсан 20.000.000 төгрөгийн торгох ялыг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 36 сарын хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоосон.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 5.3 дугаар зүйлийн 5-д зааснаар “Ш О” ХХК, шүүгдэгч А.Д нь торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солихоор шийдвэрлэжээ.

Түүнчлэн “Ш О” ХХК, шүүгдэгч А.Д-ээс байгаль орчинд учирсан хохирол 38.717.211 (гучин найман сая долоон зуун арван долоон мянга хоёр зуун арван нэг) төгрөгийг гаргуулж Байгаль орчин уур амьсгалын санд оруулахаар шийдвэрлэсэн нь гэмт хэргийн улмаас учруулсан хохирол төлүүлэх сайн жишиг болжээ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 1, 2-т зааснаар шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан 2 841 900 төгрөгийн үнэ бүхий Мазда бонго маркийн тээврийн хэрэгслийг хурааж, Л.Цогтбаатарын эзэмшлийн Fuso маркийн тээврийн хэрэгслийн үнэ 6.486.500 төгрөгийг тус тус шүүгдэгчээс гаргуулж улсын төсөвт оруулахаар шийдвэрлэжээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 2-т “гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эд хөрөнгө түүний үнэ, ...гэмт хэрэг үйлдэхэд ашигласан техник, хэрэгслийг



ойлгоно, мөн зүйлийн 4-д гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, ...зэвсэг, зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд хураан авахаар зохицуулсан тул шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан Л.Цогтбаатарын өмчлөлийн 8524 ОРО улсын дугаартай Fuso маркийн тээврийн хэрэгслийн үнэ 6 468 500 (зургаан сая дөрвөн зуун жаран найман мянга таван зуу) төгрөг, шүүгдэгчийн өмчлөлийн 2096 УБК улсын дугаартай Mazda Bongo маркийн 2 841 900 (хоёр сая найман зуун дөчин нэгэн мянга есөн зуу) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг улсын төсөвт оруулахаар шийдвэрлэсэн байна.

Тус шүүхийн шийдвэрт гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг төлүүлэхийн зэрэгцээ гэмт хэрэг үйлдэхэд ашигласан техник хэрэгслийг хураан авсан нь онцлог шийдвэр болжээ.

## ДҮГНЭЛТ

Шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхдээ 1. Танилцуулга хэсэг буюу үйл явдлын агуулгыг хамтатган хэргийн товч утга, 2. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх этгээдийг шүүхээс тогтоож буй онцлог, давхар хариуцлага хүлээлгэсэн эсэх, 3. Оногдуулж буй ялын хэмжээ, үр нөлөө, гэмт хэргийн улмаас учруулсан хохирол, хор уршиг болон тэдгээрийг нөхөн төлүүлсэн байдал зэрэгт дүн шинжилгээ хийж, эрх зүйн зохицуулалтын мөн чанар, түүний онцлог, шүүхээс хэрхэн хэрэгжүүлж буй практик, цаашид хууль хэрэглээнд анхаарах асуудлыг авч үзсэний үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж байна.

1. Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг үйлдэж буй этгээд нь нөхөн сэргээлт хийх гэрээний дагуу ажиллах явцад тэр газраа хууль бусаар олборлолт хийсэн, эсхүл нөхөн сэргээлт хийх газраас өөр газарт дур зоргоор олборлолт хийсэн, хийхийг завдсан үйлдлүүд түгээмэл ажиглагдаж байна. Харин Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 4-д заасан тусгай зөвшөөрөлтэйгөөр ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн гэмт хэрэг гараагүй байна. Шүүхийн шийдвэр 1-д хийсэн дүн шинжилгээнд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулахаар гэрээ байгуулсан хуулийн этгээд тухайн нөхөн сэргээлт хийх зардлаа тухайн газарт үүссэн байгаа хаягдал овоолго, ухагдсан нүхнээс гарсан шороо зэргийг угааж болохоор гэрээ хийсэн болон тухайн





орон нутагт хөрөнгө оруулалт хийхээр тохиролцсон байх зэрэг шинжүүд бий болсон байна. Тус шүүхийн шийдвэрээс үзэхэд нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдэд орон нутгаас дур зоргоороо өөр газар зааж өгөх, хариуд нь орон нутагт хөрөнгө оруулалт, хандив туслалцаа авдаг байдал бий болсон байх шинж ажиглагдаж байна. Энэ нь мөн гэмт хэргийн шинжтэй эсэхийг анхаарах нь зүйтэй юм.

2. Хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар шүүх шийдвэрлэж байна. Хуулийн этгээдийн төрлийн тухайд 6 нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 1 нь нөхөрлөл байсан. Хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн бол хувь хүнийг шүүгдэгчээр тогтоохгүй байгаа буюу Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д заасан “Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дах хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэснийг зөрчсөн шийдвэр түгээмэл гарчээ. Тухайлбал, нийт 7 шүүхийн шийдвэрийн 5 шийдвэрт хувь хүнд эрүүгийн хариуцлага давхар хүлээлгэлгүй ял завшуулсан нөхцөл байдал илэрч байна. Ялангуяа Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлийн Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар эргэлтэд оруулах гэмт хэргийн 3 шийдвэрийн бүгдэд нь хуулийн этгээдийг шүүгдэгчээр, компанийн гүйцэтгэх захирал болох гүйцэтгэгчийг хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээдээр тогтоосон ба эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй нь хууль зөрчсөн нөхцөл байдлыг бий болгожээ.

3. Дээрх шүүхийн шийдвэрүүдэд ял, албадлагын арга хэмжээг оногдуулсан байдлыг авч үзэхэд Эрүүгийн хуульд заасан ялын доод хэмжээг шүүхээс оногдуулах хандлагатай байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 2-т “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн

этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж хорин мянган нэгжээс нэг зуун хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”, 24.3 дугаар зүйлийн 3-д “Энэ зүйлийн 2 дах хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.” гэж заасан. Нийт ял оногдуулсан 6 шүүхийн шийдвэрийн 5-т 20.000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 20 сая төгрөгөөр торгох ял оногдуулсан ба 1-д нь 30.000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 30 сая төгрөгөөр торгох ял оноосон нь ялын хамгийн бага хэмжээг хуулийн этгээдэд оногдуулах жишиг тогтсоныг харуулж байна. Түүнчлэн торгох ялыг эдлүүлэхдээ 1-3 жилийн хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж цөөнгүй шийдвэрлэж байгаа нь шүүгдэгчийн төлбөрийн чадамжид уялдсан байх хэдий ч ялын үр нөлөөг дордуулах нөхцөл байдал үүсгэж болохоор байна.

Эрүүгийн хуулийн 9.4 дүгээр зүйлд заасан хуулийн этгээдэд оногдуулах эрх хасах албадлагын арга хэмжээний тухайд “энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нэг жилээс найман жил хүртэл хугацаагаар хуулийн этгээдэд нэг, эсхүл хэд хэдэн төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хязгаарлах, эсхүл эрх хасах албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.” гэсэн заалтын дагуу гэмт хэрэг үйлдсэн хуулийн этгээдэд 1-3 жилийн хугацаатайгаар эрх хасах албадлагын арга хэмжээ оногдуулж байна. Шүүхийн шийдвэрүүдээс харахад эрх хасах албадлагын арга хэмжээг заавал хэрэглэх хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй тохиолдол байна. Тухайлбал, ял оногдуулж шийдвэрлэсэн дээрх 6 шүүхийн шийдвэрийн 2 нь эрх хасах албадлагын арга хэмжээг оногдуулалгүй Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн бол, 1 шийдвэрт хугацаа заалгүйгээр буюу хугацаа тодорхойгүй эрх хассан нь шийдвэрийг биелүүлэхэд тодорхойгүй байдлыг бий болгожээ. Энэ нь “хуулийн





этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах **эрх хасаж** нэг зуун хорин мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ” гэсэн заалтыг зөрчсөн нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Эрүүгийн хуулийн 24.2 болон 24.6 дугаар зүйлээр шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд хөрөнгө орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэсэн тохиолдол цөөнгүй байгаа бол татан буулгах арга хэмжээг хэрэглэсэн тохиолдол шүүхэд байхгүй байна.

4. Шүүхийн шийдвэрүүдэд торгох ялыг хуулийн этгээд биелүүлээгүй тохиолдолд хуулийн этгээдийн ялыг хорих ялаар солих тухай бичсэн байна. Хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 9.2 дүгээр зүйлийн 1-д зааснаар зөвхөн торгох ял оногдуулах боломжтой бөгөөд хуулийн этгээдэд оногдуулсан ялыг биелүүлэхгүй бол хувь хүнд халдаан хэрэглэх боломжгүй юм. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.3 дугаар зүйл буюу Шударга ёсны зарчимд *“Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрцүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрцүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй.”* гэж заасан. Иймд хуулийн этгээдэд оногдуулсан торгох ялыг хорих ялаар солих, эсвэл хуулийн этгээдийн өмнөөс хувь хүнд ялыг халдаан хэрэглэх аль аль нь хууль зөрчсөн шийдвэр болжээ. Хуулийн этгээдэд Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2-т зааснаар албадлагын 3 төрлийн арга хэмжээ авах эрх зүйн зохицуулалттай боловч шүүх эрх хасах албадлагын арга хэмжээнээс бусад албадлагын арга хэмжээг хэрэглээгүй онцлогтой байна.

5. Хуулийн этгээд болон гүйцэтгэгчид хамтад нь ял оногдуулах зарчмыг хэрэглэхдээ хуулийн этгээдтэй ижил зүйлээр буюу 3 дах хэсгээр зүйлчлэх эсвэл тус зүйлийн 1-ээр зүйлчлэх зэргээр өөр өөрөөр зүйлчилж байгаа хандлага ажиглагдлаа. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлд *“Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрцүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дах хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий*

*албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”* гэж заасны дагуу хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн гэмт хэрэгт тухайн гэмт хэргийг гүйцэтгэсэн этгээдийг хамтад нь буюу давхар эрүүгийн хариуцлага хүлээлгэх тухай заалтыг нэг мөр хэрэглэх нь зүйтэй байна. Шүүхээс хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулахдаа 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлийн 3 дах хэсэгт зааснаар ял оногдуулж, хувь хүнд дээрх зүйлүүдийн 1 дэх хэсэгт зааснаар ял оногдуулж хэвших нь зүйтэй.

6. Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг тодорхойлж нөхөн төлүүлсэн байдлыг үзэхэд Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд гэмт хэргийн улмаас учруулсан хохирол тогтоогдоогүй гэж шийдвэрлэсэн бол 24.6 дугаар зүйлд заасан гэмт хэргийн тухайд хууль бусаар бэлтгэсэн модны экологийн үнэлгээг тогтоож нөхөн төлүүлэхийн зэрэгцээ шинээр мод суулгуулах байдлаар хохирлыг төлүүлж шийдвэрлэсэн байна. Тухайлбал, шүүхийн шийдвэрт гэмт хэргийн улмаас учруулсан хохирлын үнэлгээг Байгаль орчны зөвлөх үнэлгээний компаниар хийлгэж, 60 ширхэг модыг 38.717.211 төгрөгөөр тооцож Засгийн газрын сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.3-д зааснаар Байгаль орчин уур амьсгалын санд оруулахаар шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлийн 3-д заасан гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.5 дугаар зүйлийн 2-т *“гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого”* гэж Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж шууд, шууд бусаар олсон эд хөрөнгө түүний үнэ, ...гэмт хэрэг үйлдэхэд ашигласан техник, хэрэгслийг ойлгоно, мөн зүйлийн 4-д гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл, түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, ...зэвсэг, зэвсгийн чанартай зүйл нь тухайн гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд хураан авахаар зохицуулсан тул шүүгдэгчийн гэмт хэрэг үйлдэхдээ ашигласан тээврийн хэрэгслийн үнэ 6.468.500 (зургаан сая дөрвөн зуун жаран найман мянга таван зуу) төгрөг, шүүгдэгчийн өмчлөлийн Mazda Bongo маркийн 2.841.900 (хоёр сая



найман зуун дөчин нэгэн мянга есөн зуу) төгрөгийн үнэ бүхий тээврийн хэрэгслийг улсын төсөвт оруулахаар шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийн 9.2 дугаар зүйлийн 2-т заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэсэн жишиг болохуйц шийдвэр болжээ.

Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх жишиг янз бүр байгаа бөгөөд 3 шийдвэрийн 2-т нь хохирол нөхөн төлүүлээгүй бол 1 шийдвэрт байгаль орчинд учирсан экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээг шинжээчийн дүгнэлтэд дурдсан хэмжээнд гаргуулах үндэслэлтэй гэж үзэн, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дах хэсгийн 1-д зааснаар газрын хэвлийд учруулсан хохирол болон нөхөн сэргээлтийн зардлыг шүүгдэгчээр төлүүлэхээр шийдвэрлэсэн. Цаашид Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан экологи-эдийн засгийн үнэлгээ тогтоож, нөхөн төлүүлж шийдвэрлэхийн зэрэгцээ хор уршгийг тооцож, нөхөн төлүүлэх жишиг тогтоох шаардлагатайг харуулж байна. Түүнчлэн шүүхээс нөхөн төлүүлэх хохирлыг тооцохдоо зөвхөн байгалийн нөхөн сэргээлт бус биологийн нөхөн сэргээлтийг тооцож хэвших нь зүйтэй юм.

## САНАЛ

Хүрээлэн буй орчны эсрэг зарим төрлийн гэмт хэргүүдийг буюу Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлийн 3-д зааснаар шүүхээс хэрэг хянан шийдвэрлэхэд анхаарах дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Шүүхээс хуулийн этгээдийг төлөөлөх эрх бүхий этгээд гэмт хэрэг үйлдсэн бол хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэж шийдвэрлэж байна. Ингэхдээ Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д заасан *“Энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрцүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан нь энэ зүйлийн 1, 2 дах хэсэгт заасан журмын дагуу хуулийн этгээдийг төлөөлөн шийдвэр гаргасан, зөвшөөрөл өгсөн эрх бүхий албан тушаалтныг ялаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”* гэсэн заалтыг хэрэгжүүлж, хуулийн этгээдийг төлөөлөн гэмт хэргийг гүйцэтгэсэн хувь хүнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтоох бус шүүгдэгчээр татаж, давхар эрүүгийн хариуцлага оногдуулж шийдвэрлэх шаардлагатай.
2. Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлийн 3-д зааснаар торгох ялыг хуулийн этгээдэд оногдуулахдаа эрх хасах албадлагын арга хэмжээг заавал оногдуулж хэвших. Мөн эрх хасах албадлагын арга хэмжээг оногдуулахдаа шүүхийн шийдвэрт хугацааг 1-8 жилийн хугацаагаар тодорхой дурдаж шийдвэрлэх нь зүйтэй юм.



3. Шүүхээс хуулийн этгээдэд ял оногдуулахдаа торгох ялын хамгийн доод хэмжээг хэрэглэх, түүнчлэн хугацааг хэсэгчлэн төлүүлэхээр тогтоож байгаа нь түгээмэл байна. Энэ нь ялын үр нөлөөтэй байдлыг алдагдуулах хандлагатай тул хуулийн этгээдэд торгох ялыг шүүхээс оногдуулахдаа тухайн компанийн ашиг орлогын хэмжээ, эрсдэл даах чадварыг харгалзан ялын хэмжээг нэмэгдүүлэх талаар анхааран үзэх нь зүйтэй гэж үзэж байна.
4. Шүүхийн шийдвэрүүдэд торгох ялыг хуулийн этгээд биелүүлээгүй бол ялыг хорих ялаар солихоор шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийн 9.2 дүгээр зүйлийн 1-д хуулийн этгээдэд зөвхөн торгох ял оногдуулах эрх зүйн зохицуулалтыг зөрчиж байна. Түүнчлэн шүүхийн шийдвэрт хуулийн этгээдэд оногдуулсан ялыг биелүүлэхгүй бол түүнийг төлөөлөх эрх бүхий хувь хүнд халдаан хэрэглэхээр заасан нь Эрүүгийн хуулийг ноцтой зөрчсөн шийдвэр болжээ. Иймд цаашид шүүхийн шийдвэрт хуулийн этгээдэд оногдуулсан торгох ялыг бусад ялаар солих, бусад этгээдэд халдаан хэрэглэхгүй байх талаар анхаарах шаардлагатай.
5. Давхар хариуцлагын зарчим буюу Эрүүгийн хуулийн 9.1 дүгээр зүйлийн 3-д заасан гэмт хэргийн гүйцэтгэгчид эрүүгийн хариуцлага оногдуулахдаа Эрүүгийн хуулийн 24.2, 24.3, 24.6 дугаар зүйлийн 1-д зааснаар журамлан зүйлчилж хэвших нь зүйтэй байна. Зөвхөн дээрх 3 зүйлээр тогтохгүй бусад хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага оногдуулах гэмт хэргийн зүйлчлэлд үүнийг анхаарах шаардлагатай.
6. Гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхдээ байгалийн болон биологийн нөхөн сэргээлтийн үнэлгээг хийлгэж хэвших, түүнчлэн хохирлын зэрэгцээ хор уршгийг тооцож төлүүлэх сайн жишиг тогтоох нь зүйтэй.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

### Эрх зүйн эх сурвалж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992
2. Эрүүгийн хууль, 2015
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2015
4. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, 2006
5. Ашигт малтмалын тухай хууль, 2006
6. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
7. Ойн тухай хууль, 2006

### Ном өгүүлэл, бусад эх сурвалж

1. С.Гантулга, Б.Энхболд, “Эрүүгийн эрх зүй тусгай анги” сурах бичиг, УБ, 2018
2. Б.Цогтбаатар, “Ашигт малтмалыг хууль бусаар олборлох гэмт хэргийг нотлох ажиллагаа” докторын диссертацийн ажил, УБ, 2023
3. Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүн таслах ажиллагааны тайлан, 2018-2022
4. Цагдаагийн ерөнхий газар, Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын алба, Монгол Улсад бүртгэсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдал-2019, УБ, 2020

### Цахим хуудас

1. <https://www.fatf-gafi.org/en/publications/Environmental-crime/Environmental-crime.html>
2. [https://www.unodc.org/documents/NGO/EIA\\_Ecocrime\\_report\\_0908\\_final\\_draft\\_low.pdf](https://www.unodc.org/documents/NGO/EIA_Ecocrime_report_0908_final_draft_low.pdf)
3. [https://shuukh.mn/cases/2/1?fbclid=IwAR0cL\\_mWAEvVT-PLLvdPC42Iw9zxvY5xp7gXI\\_10a7P1xb7iM3HZojmCEVoU](https://shuukh.mn/cases/2/1?fbclid=IwAR0cL_mWAEvVT-PLLvdPC42Iw9zxvY5xp7gXI_10a7P1xb7iM3HZojmCEVoU)

### Шүүхийн шийдвэр

1. Баянхонгор аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018.08.10-ны өдрийн №204 цагаатгах тогтоол
2. Өмнөговь аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018.12.10-ны өдрийн №184 тоот шийтгэх тогтоол
3. Баянхонгор аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019.03.25-ны өдрийн №078 тоот шийтгэх тогтоол
4. Баянхонгор аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2020.05.13-ны өдрийн №158 тоот шийтгэх тогтоол
5. Төв аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.06.06-ны №246 тоот шийтгэх тогтоол
6. Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дах сум дундын шүүхийн 2019.06.27-ны өдрийн №42 тоот шийтгэх тогтоол
7. Хэнтий аймгийн Бор-Өндөр сум дах сум дундын шүүхийн 2019.11.20-ны өдрийн №69 тоот шийтгэх тогтоол
8. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.01.10-ны өдрийн №85 тоот шийтгэх тогтоол

9. Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.02.18-ны өдрийн №248 тоот шийтгэх тогтоол
10. Дорноговь аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.06.08-ны өдрийн №94 тоот шийтгэх тогтоол
11. Дорноговь аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.06.20-ны өдрийн №102 тоот шийтгэх тогтоол
12. Дорноговь аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2022.06.30-ны өдрийн №112 тоот шийтгэх тогтоол
13. Сүхбаатар дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2023.01.26-ны өдрийн №124 тоот шийтгэх тогтоол
14. Төв аймаг дах сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2021.08.11-ний өдрийн №297 тоот шийтгэх тогтоол



## ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН СУДАЛГАА ХАРИУЦСАН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

ДАШНЯМЫН ЗОЛЖАРГАЛ (LL.M.)  
GREEN CLIMATE FUND, АХЛАХ ХУУЛЬЧ



Д.Золжаргал нь Монголын санхүү, хөрөнгийн зах зээлийн чадварлаг мэргэжилтнүүдийн нэг бөгөөд компанийн эрх зүй, эрчим хүч, эрдэс баялгийн салбараар мэргэшсэн хуульч юм. ОУ-ын байгууллагад уригдан ажиллахаасаа өмнө Монголын томоохон арилжааны банк, бүс нутагт хүлээн зөвшөөрөгдсөн тэргүүлэх хуулийн фирм байгуулж ажилласан туршлагатай.

МУИС-ийн ХЗС-ийн Олон улсын эрх зүйн бакалавр, 2004 онд АНУ-ын Оклахомагийн их сургуулийг Бизнесийн удирдлагын магистр, Харвардын их сургуулийн Хуулийн сургуулийг Хууль зүйн магистр зэрэгтэй тус тус дүүргэсэн.

СҮХЭЭГИЙН БИЛГҮҮН (LL.M.)  
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН СУДЛААЧ



С.Билгүүн нь хууль зүйн судалгаа, сургалт, шүүхийн захиргааны чиглэлээр ажилладаг.

Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд суралцаж, “Монгол Улсад эрх зүйн зайлшгүй процессыг төлөвшүүлэх нь” сэдвээр, Япон улсын Кьюсюгийн их сургуульд суралцаж “Монгол Улс дах нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдвээр хууль зүйн магистрын зэрэг тус тус хамгаалсан.

Харьцуулсан эрх зүй, хүний эрхийн чиглэлээр судалгаа хийдэг.

НАРАНЧУЛУУНЫ ОТГОНЧИМЭГ (LL.M.)  
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН



Н.Отгончимэг нь Захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн хуульч, судлаач бөгөөд УИХ-ын тамгын газар, Олон улсын хөгжлийн хөтөлбөрүүдэд зөвлөх хийх зэргээр мэргэжлээрээ 22 жил ажилласан туршлагатай хуульч юм. 2021 оноос УДШ-ийн дэргэд байгуулагдсан Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж байна.

МУИС-ын ХЗС-ийг Магистрын зэрэгтэй, Лондоны Kings college-ийг Хууль зүйн Магистр зэрэгтэй төгссөн.

ГАНЧУЛУУНЫ ОЮУНБОЛД (LL.M.),  
МХХ-НЫ ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ ТЭРГҮҮН



Г.Оюунболд нь криминологи, эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, шүүхийн шийдвэр биелүүлэх эрх зүйн чиглэлээр мэргэшиж судалдаг практикийн болон судалгааны байгууллагад 18 жил ажилласан туршлагатай.

Цагдаагийн академид эрх зүйн бакалаврын төгсөж “Эрүүгийн байцаан шийтгэх хугацаа” сэдвээр хууль зүйн ухааны магистр зэрэг хамгаалсан. Хүмүүнлэгийн ухааны их сургуульд Менежментийн бакалаврын зэрэгтэй мэргэжлийн англи хэлний ангид суралцан төгссөн.

АЛТАНГЭРЭЛИЙН БЯМБАЖАРГАЛ (S.J.D.),  
МУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨХ



МУИС-ийн ХЗС-д төрийн захиргаа, Монгол улсын Үндсэн хуулийн эрх зүй, ҮХ-ийн процессын эрх зүй, харьцуулсан эрх зүйн хичээл заадаг. ХЗС-ийн эрдэмтэн нарийн бичгийн даргын хувиар эрдэм шинжилгээний ажил, бүтээл туурвил, Эрх зүй улирал тутмын сэтгүүлийг эрхлэн гаргах ажлыг хариуцан ажиллаж байв. 2021 оноос МУ-ын Ерөнхийлөгчийн Хууль зүйн бодлогын зөвлөхөөр томилогдон ажиллаж байна.

МУИС-ийн ХЗС-ийг дүүргэж, БНСУ-ын Күүкмений сургуульд Хууль зүйн докторын зэрэг хамгаалсан.



